

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2019 · 1 сар | Дугаар 3

ГАРЧИГ

6–9 Санхүүгийн 33–ийн оны онцлох үйл явдал

10–12 Шинэ зарчим, бодлогоор стратегия төлөвлөн ажиллаж байна

12–13 СЗХ–ноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам

14–15 Санхүүгийн зохицуулалтын арга хэрэгсэл болох Сэндбокс

15–18 Санхүүгийн 33–ийн хэрэглэгчийн итгэлийн судалгаа

18–20 “Монкорд” ХЗХ–ны хуурамч тайлан ирүүлж байсныг урьдчилан тогтоосон

20–21 Комплаенс форум

22–23 Зах зээлийн мэдээ

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хороо товхимол

- Монгол Улс, Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IV байр.
- 976 51 261611
- press@frc.mn
- www.frc.gov.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

АВСТРАЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭЧЛЭЛТ

1980–аад оныг хүртэл Австралийн эдийн засаг нь чөлөөт зах зээл төдийлөн сайн хөгжөөгүй социалист хэлбэртэй байсан. Энэ үед эрүүл мэнд, банк, боловсрол, харилцаа холбоо, тээвэр зэрэг гол салбаруудыг нь төр эзэмшиж, зохицуулж байсан бөгөөд ажилчдын цалинг төрийн зохицуулалтаар тогтоодог, гадаад худалдаа нь хангалттай нээлттэй бус, валютын тогтмол ханшийн дэглэмтэй байжээ.

1970–аад оны үед газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалсан дэлхийн эдийн засгийн хямрал тохиосон бөгөөд энэ үед Австралийн эдийн засаг экспортын бууралтын нөлөөтэй нийлүүлэлтийн шок, цалин болон засгийн газрын зардлын өндөр түвшнээс шалтгаалсан эрэлтийн шоктой байв. Уг шокийн нөлөөгөөр Австралийн эдийн засаг стагфляцитай байсан ба инфляци, болон ажилгүйдэл түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрч байжээ. Тухайн үеийн эдийн засгийн удаашрал, хангалтгүй үзүүлэлтүүдээс шалтгаалан Австралийн засгийн газар 1980–аад оноос эхлэн эдийн засгийн реформуудыг хийж эхэлсэн юм.

Тухайлбал 1983 онд Австрали улс хөвөгч ханшийн дэглэмд шилжсэн буюу валютын ханш эрэлт нийлүүлэлтийн зарчмаар зах зээлд чөлөөтэй тогтох болсо бөгөөд газрын тосны үнийн шок нь санхүүгийн салбарыг зохицуулахад тогтворгүй орчныг үүсгэж эхэлсэн нь уг шийдвэрийг гаргах үндэс болсон. Хөвөгч ханшийн дэглэмд шилжсэнээр Австралийн эдийн засаг илүү уян хатан болж, нөөцийн банк нь хүүгийн түвшнээр дамжуулан эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих боломжтой болсон юм. Мөн ханшийн дэглэмээ өөрчилснөөр гадны банкныг нэвтрүүлэх, зээлийн хязгаарлалтуудаа сулруулах, тарифаа бууруулах, цалингийн зохицуулалтыг орхих зэрэг дараа дараагийн эдийн засгийн өөрчлөлтүүдийг хийх суурь нь болсон билээ.

1890–ээд оны үед тохиосон үл хөдлөх хөрөнгийн хөөсрөлөөс¹ шалтгаалан Австрали улсын 11 арилжааны банк дампууран эдийн засгийг хямралд оруулж байсан. Үүний улмаас 100 жилийн туршид засгийн газар нь гадны банкуудыг нэвтрэхийг хориглож, банкуудад засгийн газраас хяналт тавин хүүгийн түвшнийг тогтоож байв. 1980 оноос эхлэн засгийн

газар гадны банкуудыг зах зээлд нэвтрэхийг зөвшөөрч хүүгийн түвшнийг хязгаарлахаа больж, банкуудаа хувьчилсан. 1996 онд нөөцийн банкинд мөнгөний бие даасан бодлого баримтлах эрхийг олгосон бөгөөд уг шийдвэр нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээлийг илүү үр ашигтай ажиллахад түлхэц болжээ.

Дэлхийн 2 дугаар дайны дараагаар Австралийн эдийн засаг дахь цалингийн өндөр түвшин, эдийн засгийн үр ашиггүй байдал, зохицуулалтын чанга орчин зэрэг нь импортын бүтээгдэхүүндээ татвар, квотыг ногдуулсан ч Австрали улсыг Азийн үйлдвэрлэгчидтэй өрсөлдөхөд бэрхшээл үүсгэж байсан юм. 1988 оноос эхлэн Австралийн засгийн газар үйлдвэрлэгчдээ хамгаалах бодлогоо нэмэгдүүлэх бус эсрэгээр нь цуцалж эхэлсэн бөгөөд аж, ахуйн нэгж, үйлдвэрлэгчид зах зээлд үлдэхийн тулд үйл ажиллагаагаа сайжруулж, үнийн түвшнээ бууруулж, мөн импортын бүтээгдэхүүнээс хамааралтай зарим бизнесүүдийн зардал буурснаар инфляцийн түвшин буурч эхэлсэн.

1989 онд Австралийн засгийн газар дээд боловсролын өндөр үнээс шалтгаалан нийгмийн ялгаа үүсгэхээс сэргийлэн оюутны зээлийн бодлогыг хэрэгжүүлсэн бөгөөд дээд боловсрол эзэмшигчид сургалтын төлбөрийн хүүгүй зээл аван ажилд орсныхоо дараагаар цалингаасаа суутгуулдаг тогтолцоог бий болгож байжээ. Уг тогтолцоогоор хэрвээ тухайн суралцагч ажилд орж чадахгүй бол зээлээ эргүүлэн төлөх шаардлагагүй байсан байна.

Дээрхи үйл ажиллагаануудаас гадна төрийн өмчийн аж ахуй нэгжүүдийг хувьчилсан, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг сулруулан, тогтмол цалингийн бодлогоо цуцалсан, татварын бодлогоо өөрчилсэн зэрэг эдийн засгийн реформуудыг хийж эхэлсэн.

Австралийн ДНБ–ий бүтцийг харьцуулан харвал 1977 оноос хойш уул уурхай, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ, санхүү, үл хөдлөх хөрөнгийн бизнесийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны үйлчилгээний салбарын ДНБ–д эзлэх хувь өссөн бол аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь буурсан байна.

¹ Property boom

Австралийн эдийн засаг 1961 оноос хойш 1983, 1991 онд уналттай байсан бөгөөд эдгээр үеүдэд эдийн засгийн өсөлт -2.2, -0.4 хувьтай байсан. 1970-аад оны үед бүтээмж өсөөгүй хэдий ч бодит цалингийн түвшин өссөнөөр инфляци өсөж мөн ажилгүйдлийн түвшин нэмэгдэж байжээ. Үүний үр дүнд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 1970-аад оны үед удааширсан байна.

Эдийн засагт хийгдсэн реформуудын үр дүнд Австрали улсын бүтээмж нэмэгдэн эдийн засаг нь өсөж эхэлсэн бөгөөд 1991 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй 26 жил өсөлттэй байна.

1960, 1970, 1980-аад оны эхэн үеүдэд Австралийн эдийн засаг нь чанга зохицуулалттай, төрийн монополь салбаруудтай, бүтээмж, өсөлтийн түвшин доогуур тааруу эдийн засгийн үзүүлэлттэй байсан гэж судлаачид нь үздэг. 1980, 1990-ээд оноос эхлэн эдийн засагт хийгдсэн реформуудын үр дүнд Австралийн эдийн засаг илүү нээлттэй, уян хатан, өндөр бүтээмжтэй болжээ.

1960 оноос хойш эдийн засгийн өсөлтийн динамикийг 10 жилийн интервалаар харвал дундаж өсөлт буурах хандлагатай байгаа хэдий ч, өсөлтийн хэлбэлзэл буурсан байна. Өөрөөр хэлбэл Австралийн эдийн засаг илүү тогтворжиж эхэлсэн. 2000 оноос хойш сүүлийн 16 жилийн өсөлтийн түвшин нь өмнөх жилүүдтэй харьцуулахад илүү тогтвортой байна.

Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлтийг бүтээмжийн өсөлттэй холбож тайлбарладаг бөгөөд 1980-аад оны үед Австралийн бүтээмжийн үзүүлэлт Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллаг (OECD)-ын гишүүн орнуудтай харьцуулахад нилээд доогуур байсан бол 1990-ээд оноос эхлэн бүтээмжийн үзүүлэлтээрээ дээгүүрт орох болсон. 1990-ээд оны 2 дугаар хагас гэхэд Австрали улсын нэг хүнд ногдох орлогын түвшин өсөж эхэлсэн.


1950 онд Австрали улс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр дэлхийд 4-т байсан бол 1983 онд уг байр ухран 14-т орсон юм. Харин 2008 онд Австрали улс 5 дугаар байр хүртэл урагшилсан бөгөөд 2016 оны байдлаар уг үзүүлэлтээр 10 дугаар байранд жагсаж байна. Австрали улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 1960 онд 1809 доллар байсан бол 1980 онд 10202 доллар, 2000 онд 21691 доллар байсан бол 2013 онд хамгийн өндөр буюу 67792 доллар байсан. 2016 оны байдлаар Австрали

Хүснэгт. Австралийн ДНБ, салбараар

	1977	1987	1997	2017
Хөдөө аж ахуй, загас барилт	4.8%	3.9%	3.7%	3.3%
Уул уурхай	4.4%	4.3%	5.5%	6.9%
Аж үйлдвэр	17.1%	14.5%	12.2%	6.9%
Цахилгаан, цэвэр, бохир усны үйлчилгээ	4.1%	4.7%	4.2%	6.9%
Барилга	9.3%	7.8%	7.0%	8.7%
Бөөний болон жижиглэн худалдаа	11.3%	9.7%	9.7%	10.3%
Байр сууц, хүнсний үйлчилгээ	3.5%	3.2%	3.2%	2.9%
Тээвэр, агуулахын үйлчилгээ	5.2%	5.7%	5.9%	5.7%
Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ	1.1%	1.6%	2.6%	3.2%
Санхүү, үл хөдлөх хөрөнгийн бизнесийн үйлчилгээ	8.0%	10.6%	11.8%	14.0%
Төрийн удирдлага	11.2%	11.5%	11.2%	10.2%
Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны үйлчилгээ	16.3%	18.9%	19.5%	22.1%
Бусад	3.9%	3.7%	3.6%	3.0%

Эх сурвалж: Австралийн статистикийн хороо

Зураг. ДНБ-ий өсөлт



Эх сурвалж: Австралийн статистикийн хороо

Зураг. Нэг хүнд ногдох ДНБ



Эх сурвалж: Австралийн статистикийн хороо

улсын нэг хүнд ДНБ-ий хэмжээ 49927 доллар байна. 1970-аад оныг хүртэл Австрали улсын инфляцийн түвшин болон ажилгүйдлийн түвшин хөөулаа бага хэмжээнд байсан бөгөөд 1970-аад оны эхэн үед 2 хувь байсан ажилгүйдлийн түвшин 1970-аад оны сүүл үе гэхэд 6.8 хувьд хүртэл өссөн. Энэ үеэр Австрали улсын эдийн засаг нийлүүлэлт болон эрэлтийн талын шоктой

байсан. Цалин болон засгийн газрын зардлын огцом өсөлт нь эрэлтийг нэмэгдүүлж, 1973 онд тохиосон Газрын тосны үнийн өсөлт нь олон улсын хямралыг бий болгж Австрали улсын экспортын эрэлтийг бууруулсан. Нийлүүлэлт болон эрэлтийн шокийн нөлөөгөөр инфляцийн түвшин өссөн. Мөн цалингийн өсөлт нь хөдөлмөрийн зах зээлийн өртөгийг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг нэмэгдүүлжээ.

ТӨРИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГЫН ХУВЬЧЛАЛ

ХУВЬЧЛАЛ ХИЙХ БОЛСОН ШАЛТГААН

1980–аад оны сүүл үе хүртэл төрийн өмчит байгууллагууд нь Австралийн эдийн засгийн голлох хэсэг байсан ба төрийн өмчит байгууллагууд нь ДНБ–ий 10 хувь, цэвэр капиталын хөрөнгийн 16 хувийг бүрдүүлдэг байсан бөгөөд эрчим хүч, ус, хий, харилцаа холбоо зэрэг салбаруудад цор ганц нийлүүлэгч нь байв. Мөн улсын хэмжээнд засгийн газар нь банк, санхүү, тээврийн салбарт оролцоотой байжээ.

Австралийн урсгал дансны алдагдал нь арав гаруй жилийн хугацаанд ДНБ–ий 4.5 хувьтай тэнцэхүйц байсан бөгөөд гадаад өр төлбөрийн өндөр өсөлт нь 1980–аад онд Австралид тулгарч байсан эдийн засгийн чухал асуудал байсан юм. Энэ асуудал нь 1990–ээд он хүртэл үргэлжилсэн ба санхүүгийн зах зээл, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг бууруулах, сангийн болон мөнгөний зохистой бодлого баримтлах, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх шаардлага үүсч эхэлсэн. Төрийн өмчийн хувьчлал нь 1990–ээд оноос эхэлсэн бөгөөд тухайн үед 85 тэрбум гаруй долларын төрийн өмч хувьчлагдсан байна.

Австрали улс бүтээмжийн үзүүлэлт, өрсөлдөх чадвар муудсан, мөн төсөвт санхүүжилт хэрэгтэй болсон гэсэн 2 үндсэн шалтгаанаар төрийн өмчийн хувьчлалыг эхлүүлсэн. Төрийн өмчит байгууллагууддаа реформ хийх болсон шалтгаануудыг дурдвал:

- 1980–аад оны эхэн үед тохиосон цаг үеийн өөрчлөлт нь Австрали улсын аж ахуй нэгжүүдийг илүү мэргэжлийн байхыг шаардаж эхэлсэн
- 1970–аад оноос эхтэй төсвийн тэнцвэргүй байдлаас шалтгаалан засгийн газар нийгмийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хадгалж үлдэхийн тулд төрийн өмчит аж ахуй нэгжүүдэд олгодог цэвэр төлбөрөө бууруулж, үйл ажиллагааны хураамжийг нь нэмэгдүүлж эхэлсэн
- 1987 онд дэлхий даяар хөрөнгийн зах зээл богино хугацаанд огцом унаж, томоохон хямрал үүсэхэд хүргэсэн. Уг хямрал нь хувьцааны хэт өндөр үнэлгээ, програмчлагдсан арилжааны системийн хэт их ашиглалтаас шалтгаалсан бөгөөд Япон, ХБНГУ, АНУ зэрэг улсууд бодлогын хүүгээ өсгөж, хумих бодлого явуулснаар зах зээлд сөрөг хүлээлт үүсч, дэлхий дахин АНУ–ын хувьцааг худалдаж эхэлсэн. Хувьцааны хөрвөх чадвар муудсанаар олон улсын хөрөнгийн зах зээл дунджаар 25 хувиар унаж, тэр дундаа Австрали улсын

хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 40 хувиар унасан юм. Энэхүү хямрал болсноор Австрали улс макро болон микро эдийн засгийн түвшинд бодлогын шинэчлэлүүд хийх шаардлагатай болсон

- Австралийн эдийн засгийн үзүүлэлтүүд суларч эхэлсэн бөгөөд 1980–аад оны сүүл үеэр Австралийн бүтээмжийн өсөлт OECD–н гишүүн орнуудтай харьцуулахад доогуур байсан
 - Мужуудын дунд хөрөнгө оруулалт татахтай холбоотой өрсөлдөөн үүсч эхэлсэн
 - Шинэ Өмнөд Уэльсийн усжуулалтын систем зэрэг томоохон аж ахуй нэгж, салбарууд алдагдалтай үйл ажиллагаа явуулж эхэлсэн
 - Викториа, Өмнөд Австрали дахь төв банк, бусад санхүүгийн байгууллагуудын уналт нь улсын өрийг нэмэгдүүлж, дарамт үүсгэсэн
 - Банкны салбарт хийгдсэн зохицуулалт нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, гадны банкуудыг зах зээлд нэвтрэхийг зөвшөөрснөөр төрийн өмчит банкуудын зах зээлд эзлэх хувийг бууруулж, ашигт ажиллагаанд нөлөөлж эхэлсэн
 - Австралийн засгийн газарт зээлжих зэрэглэлээ AAA хэвээр хадгалахын тулд өр төлбөрөө бууруулах шаардлага тулгарсан
- Австралид хийгдсэн хувьчлал нь ерөнхий 2 төрөлд хуваагддаг. Нэгдүгээрт өрсөлдөөн өндөртэй салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудыг хувьчлах байв. Ийм төрлийн байгууллагуудыг хувьчлах


нь харьцангуй амар байдаг байна. Хамтын нөхөрлөлийн банк, Шинэ өмнөд Уэльсийн төрийн банк, Өмнөд Австралийн төрийн банк, BankWest зэрэг нь хувьчлагдахаасаа өмнө хувийн банкууд болон арилжааны компаниудтай хүчтэй өрсөлддөг байсан. Харин өрсөлдөөн багатай салбарт үйл ажиллагаа явуулдаг буюу монополь шинжтэй байгууллагыг хувьчилснаар монополийн хүчийг сөргөөр ашиглаж болзошгүй байдаг тул зохицуулалтын орчинг маш сайн бүрдүүлэх шаардлагатай байв.

Өмнөд Австрали болон Викториа дахь эрчим хүчний компанийн хувьчлал үүний нэг жишээ бөгөөд уг хувьчлалтай холбоотойгоор эрчим хүчний үүсгүүр, шилжүүлэг, түгээлт, болон борлуулалт зэргийг зохицуулах шаардлагатай болов.

Австрали улсын хувьчлал нь санхүү, тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, эрүүл мэнд, бизнесийн салбаруудад явагдаж эхэлсэн бөгөөд OECD–н бусад улс орнуудын адилаар өрсөлдөөн өндөртэй салбарт үйл ажиллагаа явуулж байсан аж ахуй нэгжүүдээс эхлэн хувьчилсан.

Австрали улс нь санхүүгийн зохицуулалтыг бууруулах бодлого явуулж байсан учраас санхүүгийн үйлчилгээний салбараас төрийн өмчийн хувьчлалыг эхлүүлсэн бөгөөд Хамтын нөхөрлөлийн банкний 1991, 1993, 1996 онуудад 3 үе шаттайгаар хувьчилсан бөгөөд мөн төрийн эзэмшилд байсан 3 банк, мужийн даатгалын компаниудыг хувьчилсан.

Зураг. Австралийн төрийн өмчийн хувьчлал салбараар



Австралийн засгийн газар төрийн өмчит аж ахуй нэгжүүдээ корпорацичлал, хувьчлал гэсэн 2 ерөнхий алхмаар хувьчилсан.

КОРПОРАЦИЧЛАЛ

Суурь нөхцөл: Австралийн төрийн өмчит байгууллагууд нь хуулиар тогтоогдсон эрх мэдлийн дагуу эсвэл үйл ажиллагааг нь зохицуулсан тусгай хуулийн хүрээнд корпораци хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байсан. 1988 оноос эхлэн Аудитын хороо болон бусад шинжээчид төрийн өмчит байгууллагуудын менежмент болон үр ашигт байдал маш муу байна гэж дүгнэсэн бөгөөд төрийн өмчит

байгууллагуудад хувийн байгууллагуудаас илүү давуу тал олгоггүй, өрсөлдөөнт орчинд үйл ажиллагаа явуулахыг зөвлөх болжээ.

Корпорацичлалын суурь зарчмууд: Корпорацижуулах ажлын хүрээнд төрийн өмчит байгууллагуудыг нөөцөө үр ашигтай зарцуулахын тулд дараах 5 нөхцөлийг баримтлах хэрэгтэй хэмээн тодорхойлсон.

борлуулах замаар хувьчилж байсан. Хамтын нөхөрлөлийн хувьчлалын талаас их хувь нь хувьцаа гаргах замаар хийгдэж байсан бол Викториагийн хувьчлалын 80-аас их хувь нь худалдан борлуулах замаар хийгдсэн. Австрали улсад хийгдсэн хувьчлалын борлуулалтын үнэ нь ихэвчлэн анхны хүлээлтээсээ давж байжээ.

Хувьчлалын үйл ажиллагаа болон арга хэрэгсэл: Австралийн эдийн засаг нь хувьцаа гаргах, худалдах, менежментийн аутсорсинг хийх зэрэг хувьчлалын бүхий л арга хэрэгслийг ашиглаж байсан бахувьчлалын аргуудыг ихэвчлэн дараах байдлаар сонгон ашигласан.

- Өрсөлдөөнт зах зээлд үйл ажиллагаа явуулдаг, нэр хүндтэй төрийн өмчит байгууллагуудыг хувьцаа гаргах замаар хувьчилж байв. Жишээлбэл Хамтын нөхөрлөлийн банк, TABCORP, Telstra зэргийг хувьцаа гарган хувьчилсан бөгөөд ихэнх хувьцааг нь ажилчид нь худалдаж авсан.
- Хувьцаа гаргах, мөн шууд худалдах аргуудыг хослуулан хэрэглэж болдог бөгөөд Күйнланд болон Баруун Австралийн засгийн газар төрийн банкуудыг хувьцаагаар худалдаалснаар бусад банкуудын сүлжээнд орж, уусах боломжтой гэж үзсэн тул дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь хамгаалах зорилгоор уг 2 аргыг хамтад нь ашиглаж байсан.
- Монополь шинж чанартай байгууллагуудыг шууд худалдан борлуулж байсан.
- Лаборатори, инженер зэрэг илүү техникийн салбаруудад менежментийнх нь хувьд хувьчлал хийж байсан.

Санхүүгийн онолын дагуу бол компаниудыг хувьчлахдаа шууд худалдахын оронд хувьцаа гаргах замаар хувьчилснаар илүү орлого олно гэж үздэг хэдий ч дараах шалтгаануудын улмаас Австрали нь худалдах аргыг илүү хэрэглэж байсан.

- Зохицуулалт болон зах зээлийн орчин нь харьцангуй шинэ, тодорхой бус, санхүүгийн тайлан нь асуудалтай байгууллагуудын хувьд худалдан авагч нь үнэ цэнэ, эрсдэлийг нь үнэлэх илүү чадвартай учраас худалдан борлуулдаг
- Корпорацийн хуульд заасны дагуу хувьцаа гаргахдаа үнэ, өгөөжийн таамаглалыг судалж мэдээллээр хангах шаардлагатай байдаг тул хувьцаа гаргах арга нь өртөг өндөртэй, цаг хугацаа их шаарддаг
- Хувьцаа гаргахтай адилаар худалдах үнэ нь илүү өндрөөр үнэлэгдэх боломж байдаг

Үр дүн: Үр ашгийг нэмэгдүүлэх нь төрийн өмчийн хувьчлалын үндсэн зорилго байсан ба

Хүснэгт. Корпорацичлалын баримтлах нөхцөл

Нөхцөл	Тайлбар
Тодорхой зорилго	Төрийн өмчит байгууллагууд зорилгоо нийгмийн, зохицуулалтын, эсвэл арилжааны эсэхийг нь тодорхойлон, зорилгодоо төвлөрсөн менежментийн бодлого баримтлах
Менежерил удирдлага	Байгууллагын үнэт зүйлсээ максимум байлгаж чадах боловсон хүчнээр байгууллагын гол дотоод шийдвэрүүдийг гаргуулах
Үйл ажиллагааны хяналт	Хараат бус үнэлгээ, хяналтыг хэрэгжүүлэх
Урамшуулал болон хариуцлагын тогтолцоо	Урамшуулал болон хариуцлагын тогтолцоогоор үр ашгийг нэмэгдүүлэх
Өрсөлдөөнд давуу тал олгохгүй байх	Төрийн өмчит үйл ажиллагаанд ямар нэгэн давуу тал олгох нь бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартыг бууруулах, хэрэглэгчдийг хохироох нөлөөтэй тул өрсөлдөөний давуу талыг олгохгүй байх

Төрийн болон хувийн байгууллагуудын үйл ажиллагааны онцлогт суурьлан төрийн өмчит байгууллагуудыг корпорацичлахын тулд дараах үйл ажиллагааны зохицуулалтыг гаргаж ирсэн.

- Төрийн секторт үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагууд нь засгийн газрын нийгэм, эдийн засгийн зорилгоос хараат бусаар хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэн, өмчийн эзэмшлийг сайд хариуцдаг арилжааны хэлбэрээр байгуулагдан, зах зээлд оролцох
- Зохицуулалтын болон бодлогын зөвлөгөө өгөх байгууллагууд нь төрийн өмчит аж ахуй нэгжүүдээс тусдаа байх
- Төрийн өмчит аж ахуй нэгжүүдэд төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулах, томилгоог өмчийг эзэмшиж буй сайд, ерөнхий сайд, эрдэнэсийн сангийн эрхлэгчид 12 нар хийх
- Төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн байгууллагын хөрөнгийн өгөөжийг хамгийн өндөр түвшинд хүргэх зорилго тавин ажиллах бөгөөд сайд нь урамшуулал болон хариуцлагыг тооцдог байх
- Төлөөлөн удирдах зөвлөл нь байгууллагын гүйцэтгэх удирдлагыг томилох, халах, цалин урамшууллыг тогтоох шийдвэрт оролцдоггүй байх
- Сайд болон төлөөлөн удирдах зөвлөлийн хооронд албаны бус харилцаа үүсэхгүй байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх
- Төлөөлөн удирдах зөвлөл нь жил бүр

сайдад үйл ажиллагааны хүрээ, зорилго, зорилт, санхүүгийн харьцаа, ногдол ашгийг тооцон танилцуулдаг байх

- Хувийн байгууллагуудын адилаар үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа ил тод мэдээлдэг, хариуцлага хүлээдэг байх
- Төрийн өмчит аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хувийн байгууллагуудын мэргэжилтэн, шинжээчид хяналт тавин, үнэлгээ өгдөг байх

Корпорацичлалын үр дүн: 1994 оныг хүртэл 6 жилийн хугацаанд /Грейнерийн засгийн газрын үед/ Шинэ Өмнөд Уэльсэд 5 төрийн өмчит байгууллагыг корпорацичилж, 3 байгууллагыг хувьчилсан бөгөөд уг үйл ажиллагааны үр дүнд:

- Мужийн эрчим хүч, усан хангамж, тээврийн салбаруудад хөдөлмөрийн бүтээмж 78 хувиар өссөн
- Цэвэр өр төлбөр 1990–1994 оны хооронд 27 хувиар буурсан
- Төрийн өмчит байгууллагуудын ногдол ашгийг хэмжээ 1 тэрбум доллараар нэмэгдэж 1993–1994 онд жилийн орлого 22.4 тэрбум долларт хүрч, 5 хувиар өссөн
- Бодит үнийн түвшин буурсан

ХУВЬЧЛАЛ

Австрали улсад төрийн өмчит байгууллагуудын хувьчлал ихэвчлэн мужуудын хэмжээнд хийгдэж байсан ба ихэнхдээ худалдан

хувьчлалыг хэрэгжүүлснээр засгийн газрын өрийг багасгаж, эдийн засгийн хөгжлийн

нэг хөдөлгүүр болсон. Үүнээс гадна дэлхийн санхүүгийн зах зээлийн даяарчлал явагдаж

гадны хөрөнгө оруулалт их хэмжээгээр орж ирж хямралаас гарахад нэмэр болсон байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Гадаад валютын зах зээлтэй адил Австралийн өрийн зах зээл нь 1980-аад онд санхүүгийн салбарын зохицуулалтыг бууруулснаар өсөж эхэлсэн. Австралийн өрийн зах зээл нь урт ба богино хугацаат өрийн зах зээлээс бүрддэг. Урт хугацаат өрийн зах зээлийн бүтцийг авч үзвэл Хамтын нөхөрлөлийн үнэт цаас, засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/, компанийн бонд, ипотекийн зээлээс бүрддэг бол богино хугацаат өрийн зах зээл нь богино хугацаат банкны үнэт цаас, ЗГҮЦ, компанийн үнэт цааснаас бүрддэг.

Урт хугацаат өрийн зах зээл нь хамгийн идэвхтэй бөгөөд нийт арилжааны хэмжээ улсын нийт өртэй уялдаатай байдаг. Хамтын нөхөрлөл бондын зах зээлийг хөгжүүлэх үүднээс зах зээлд гаргаж буй бондын бүтэц, төрлүүдээ шинэчилж арилжааг идэвхижүүлсэн. 1985 онд Хамтын нөхөрлөл 300 сая долларын дундаж хэмжээтэй 153 төрлийн бонд санал болгож байсан одоогоор 51 төрөл болгон бууруулаад байна. Үүнээс 4–5 тэрбум долларын дүнтэй 20 төрлийн жишиг бондууд дийлэнхи хувийг эзэлдэг. Эдгээр бондууд нь 1980 онд зах зээлийн 30%-ийг эзэлдэг байсан бол өнөөдрийн байдлаар нийт бондын зах зээлийн 97%-ийг эзэлж зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулж байна. Австралийн урт хугацаат өрийн зах зээлийн нэг онцлог нь компанийн бонд сайн хөгжөөгүй байдаг.

Австралийн урт хугацаат өрийн зах зээлийн нэг онцлог нь компанийн бонд сайн хөгжөөгүй явдал юм. 1970–1980 оны өндөр инфляцитай үед зээлдэгч нар урт хугацааны зээлийн гэрээнд орох хүсэлгүй байсан. Компаниуд ихэвчлэн бондоо гадаадын хөрөнгийн зах зээлд гаргадаг бөгөөд 1993 оноос хойш Австралийн бондын зах зээлд нийт компанийн бондын хэмжээ буурсаар байна.

Австралийн богино хугацаат өрийн зах зээл сүүлийн үед унах хандлагатай байгаа. 1980-аад онд банкуудад заавал байлгах нөөцийн шаардлага /Statutory Reserve Deposit/ тавьж эхэлснээс хойш мөнгөн тэмдэгтийн арилжаа огцом өссөн. Заавал байлгах нөөцийн шаардлага нь мөнгөн тэмдэгтэй холбоотой санхүүгийн хэрэгсэлд нөлөөлдөггүй байсан тул энэхүү шаардлагаас зугтахын тулд банкууд богино хугацаат өрийн хэрэгслүүдээ мөнгөн тэмдэгтэй холбож эхэлсэн бөгөөд 1988 заавал байлгах нөөцийн шаардлагыг "non-call-

Хувийн бондын зах зээл 2007 оны байдлаар ДНБ – ийн 57 хувийг эзлэх болсон нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон Кэингрюү (Kangaroo) бондын зах зээл буюу гадаад иргэдийн австрали доллараар дотоодод гаргасан бондын хэмжээ өссөнтэй холбоотой.

able deposits"–оор сольсноор энэхүү зах зээл унаж эхэлжээ.

Харин Засгийн газар сангийн хатуу бодлого баримталж байгаатай холбоотойгоор нээлттэй бондын зах зээлийн хэмжээ олон улсын стандарттай харьцуулахад харьцангуй бага байгаа ба ДНБ-ийн 13 хувийг эзэлж байна.

Үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээл /market in interest rate derivatives/: Зээлийн хүү дээр суурилсан дериватив нь биржийн болон биржийн бус зах зээл дээр маш идэвхтэй байдаг. Гадаад валютын арилжааны деривативын зах зээлийн хувьд своп, фьючерсын гэрээ мэт энгийн хэрэгслүүд идэвхтэй арилждаг.

1979 онд Сидней фьючерсын бирж /СФБ/ дээр хүүгийн дериватив эхэлснээр АНУ-аас гадна хүүгийн дериватив арилжаалж эхлэх анхны улс болсноор хүүгийн дериватив зах зээл хурдацтайгаар хөгжиж эхэлсэн бөгөөд 75% нь мөнгөн тэмдэгт дээр суурилсан гэрээнүүд, 25% нь 3-жилийн болон 10-жилийн бондуудаас бүрддэг. Опцион гэрээнүүд хүүгийн деривативын арилжааны 10% эзэлдэг байна.

ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛ

Бусад санхүүгийн зах зээлийн адил Австралийн хөрөнгийн биржийн /АХБ/ нийт арилжааны хэмжээ өнгөрсөн 10 жилийн туршид хүчтэй өссөн. Санхүүгийн зохицуулалтыг бууруулсны дараагаар 1995 онд АХБ-ийн арилжааны хэмжээ 133 тэрбум доллар хүрч дээд амжилтаа тогтоож байжээ. Энэ нь гурван жилийн өмнөх үетэй харьцуулахад хоёр дахин өссөн үзүүлэлт юм. Мөн зах зээлийн үнэлгээ 10 жилийн өмнөхөөс тав дахин өсөж 546 тэрбум доллар хүртэл өссөн нь бүртгэлтэй компаниудын үнэлгээ өссөнтэй холбоотой юм.

Санхүүгийн зах зээлийн даяарчлал Австралийн хувьцааны зах зээлийн өсөлтөд өндөр нөлөөтэй. 1985 онд нийт 15 тэрбум долларын зах зээлийн үнэлгээтэй 18 компани байсан бол 10 жилийн дотор бүртгэлтэй гадаад компанийн тоо 49 болж зах зээлийн үнэлгээ нь 217 тэрбум доллар болсон байна. Харин 2017 оны 11



дүгээр сарын байдлаар АХБ дээр бүртгэлтэй гадаад компанийн тоо 136 байна. 1995 он гэхэд гадаад хөрөнгө оруулагчид АХБ-ын нийт арилжааны 25 орчим хувийг гүйцэтгэж байв. Хөрөнгийн зах зээлийн дэвшлийг дагаад иргэдийн оролцоо давхар нэмэгдсэн юм. 1994 он гэхэд нийт насанд хүрэгчдийн 21 хувь хувьцаа эзэмшиж байсан. Энэ нь АНУ 25 хувь, Англи 22 хувь, Японы 24 хувийн зах зээлийн оролцоотой дүйцэхүйц болсон. Австралийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь 2000–2007 онд 47 пунктээр өссөн бөгөөд энэ нь бүртгэлтэй компанийн тооны өсөлтөөс бус, хувьцааны үнэлгээ эрчимтэй өссөнтэй холбоотой байв.

Эдгээр дэвшлээс үүдэн Австралийн хувьцааны зах зээл 1995 он гэхэд нийт арилжааны хэмжээгээр OECD-ын улсуудаас ес дэх хамгийн идэвхтэй зах зээлд бичигдсэн. Азийн зах зээлтэй харьцуулахад зах зээлийн үнэлгээгээр Япон, Хонгконгийн араас гуравт бичигдэж эхэлсэн юм. Харин нийт арилжааны хэмжээгээр авч үзэхэд тавт жагссан. Үүнээс харахад Австралийн зах зээл Азийн зарим зах зээлийг бодвол хувьцаа эзэмшилт харьцангуй тогтортой түвшинд хүрсэн.


Хувьцаанд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн хувьд СФБ болон АХБ-ийн охин компани болох Австралийн деривативсийн бирж /АДБ/ дээр арилждаг бөгөөд 163 тэрбум доллар, 77 тэрбум долларын арилжаа тус тус хийгддэг.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2018 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

1. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ 15-Д ХҮРЛЭЭ

Санхүүгийн (банкаас бусад) салбарын зах зээлд эзлэх хувь хэмжээ өсөн нэмэгдэж байна. Хөрөнгийн зах зээл, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж зээлийн хоршооны салбарын нийт 2000 гаруй мэргэжлийн оролцогч Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад багтдаг. Эдгээр байгууллагын нийт эдийн засагт эзлэх хувь хэмжээ өндөр биш ч сүүлийн жилүүдэд тасралтгүй өссөөр байна.

Тэр дундаа хөрөнгийн зах зээл хамгийн өндөр өсөлттэй байгаа ба хөгжлийн үндсэн үзүүлэлт болох зах зээлийн үнэлгээ 2.4 их наяд төгрөгт хүрлээ. Даатгалын компани, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж зээлийн




хоршоодын нийт хөрөнгийн хэмжээ 2018 оны гуравдугаар улиралд 1.7 их наяд төгрөгт хүрч, 2017 оны жилийн эцсээс 26 хувиар өссөн дүнтэй байна.

Хадгаламж, зээлийн хоршооны салбарын хөгжлийн үзүүлэлт сүүлийн 10 жилд

тохиоогогүй өндөр өсөлтийг үзүүлж, нийт хөрөнгө 34.8 хувиар өссөн бол банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө 1.2 их наяд төгрөгт хүрч 32.7 хувиар, даатгалын зах зээлийн нийт хөрөнгө 30 хувиар тус тус өсөв. Ингэснээр санхүүгийн зах зээлийн ДНБд эзлэх хэмжээ 2018 онд 15 хувь боллоо.

2. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИА БАТАЛЛАА

Санхүүгийн зохицуулах хороо дунд хугацааны буюу 2018–2021 оны стратеги төлөвлөгөөгөө батлан хэрэгжүүлж эхэллээ. Зах зээлийн өсөлт хөгжил, тогтвортой байдлыг бодлогоор чиглүүлж, түүнийхээ үндсэн дээр зохицуулалт хийн холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс бусад улс орны санхүүгийн хөгжлийн чиг хандлагын дагуу алсын хараа, дунд болон богино хугацааны зорилго, зорилтыг тодорхойлж, хэмжигдэхүйц бодит үр дүнд хүргэх зарчмыг баримтлан боловсруулсан “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө 2018–2021” нь санхүүгийн салбарыг нэгдсэн байдлаар харилцан уялдаатайгаар хөгжүүлэх, оролцогч тал бүрийг хамарсан бодлогод чиглэж буйгаараа онцлог юм.



3. ЗАХ ЗЭЭЛД МӨРДҮҮЛЖ БҮЙ ДҮРЭМ, ЖУРМУУДЫГ ШИНЭЧИЛЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын салбартаа нийт 200 орчим дүрэм, журмыг мөрдүүлж ажилладаг. Зохицуулалтын журам, дүрмийг шинэчлэн сайжруулах, нэгтгэн цэгцлэх, Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль, эрх зүйн шинэчлэлд нийцүүлэх ажлын хүрээнд

зах зээлд мөрдүүлж буй бүх журам, дүрмийг цэгцэлж, салбарын оролцогчид, мэргэжилтэн судлаачид болон олон нийтээр хэлэлцүүлэн боловсруулаад байна. 2018 онд хөрөнгийн зах зээл, даатгал, хадгаламж, зээлийн хоршооны 50 орчим дүрэм журмыг шинэчлэн боловсруулж Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлээд байна.

4. САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД МӨНГӨ УГААХ ЭРСДЭЛИЙН ИЖ БҮРЭН ҮНЭЛГЭЭГ АНХ УДАА ХИЙЛЭЭ

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын нийт оролцогчдыг хамруулсан мөнгө угаах эрсдэлийн үнэлгээг Санхүүгийн зохицуулах

хороо анх удаа хийлээ. Энэхүү эрсдэлийн үнэлгээ нь цаашид эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх, бодлогын оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болов.

Үнэлгээний үр дүнд санхүүгийн

байгууллагуудын эрсдэл дундаж түвшинд гарлаа. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлагчдыг эрсдэлийн үнэлгээнд хамруулсан нь бодлого боловсруулагчдын зүгээс уг салбарт хийж буй мөнгө угаах эрсдэлтэй холбоотой анхны судалгаа боллоо.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Банк болон санхүүгийн байгууллагын нэр хүнд зах зээл дэх хууль журмыг баримталдаг, мэргэжлийн болон ёс зүйн стандартаас шууд хамаардаг. Санхүүгийн байгууллагын хувьд итгэл даах нэр хүнд нь хамгийн үнэт өмч нь юм.

Эрсдэлд суурилсан үйл ажиллагааг нэвтрүүлэх чиглэлээр

2018 05 сар

Банкнаас бусад санхүүгийн салбарт эрсдэлийн үнэлгээ хийх зорилгоор үнэлгээний судалгааны асуулгыг Олон улсын валютын сангийн тусламжтайгаар боловсруулсан

Эрсдэлийн нэгдсэн үнэлгээний үр дүн

Салбар	Эрсдэлийн дундаж үнэлгээ	Маш бага эрсдэл	Бага эрсдэл	Дундаж эрсдэл	Өндөр эрсдэл	Маш өндөр эрсдэл
Үнэт цаас	2.49	-	4.8%	85.7%	9.5%	-
Даатгал	2.73	-	67.0%	33.0%	-	-
ББСБ	2.17	-	26.8%	73.8%	0.2%	-
ХЗХ	2.40	-	7.5%	88.2%	4.3%	-

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийн анхан шатны нэгж нь санхүүгийн гүйлгээ хийж буй харилцагчидтай шууд харьцдаг албан хаагчид юм.

6. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТҮҮХЭН ДЭХ ХАМГИЙН ӨНДӨР ӨСӨЛТ ГАРАВ


Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ) 2018 онд түүхэн дээд түвшинд буюу 2.4 их наяд төгрөгт хүрлээ. Зөвхөн 2018 оны гуравдугаар улирлын ЗЗҮ гэхэд л гурван жилийн өмнөх мөн улирлын дүнгээс 80 гаруй хувиар нэмэгдсэн байна.

Түүнчлэн 1995 оноос хойш 2018 он хүртэл Монголын хөрөнгийн зах зээлд хийсэн нийт хувьцааны арилжааны дүн анх удаа 1.0 их наяд төгрөгт хүрсэн, хөрөнгийн зах зээлийн чиг

хандлагыг илэрхийлдэг ТОП20 индекс сүүлийн 10 жилд буюу 2008 оноос хойш 288 хувиар өссөн.

Үнэт цаасны компаниудаар дамжуулан 398,000 гаруй иргэн үнэт цаасны дансаа шинээр нээлгэсэн бөгөөд энэ нь 1990 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт байв. Зах зээл дэх эдгээр өсөлтийн үзүүлэлтүүд нь Монголын үнэт цаасны зах зээл сүүлийн жилүүдэд хэрхэн хурдацтайгаар идэвхижиж, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэж байгааг илтгэж байгаа бөгөөд цаашлаад тогтвортой өсөн дэвжихийн үндэс суурь болж байна.

Зураг. Зах зээлийн үнэлгээ /Тэрбум төгрөг/



5. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИНГ БҮРДҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 339 дүгээр тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталлаа.

Тус журмын онцлог нь мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийх хяналт шалгалтыг олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу эрсдэлийг үнэлэх асуулга, матриц, аргачлалд тулгуурлан явуулахаар зохицуулсанд оршино.

7. ХАМГИЙН ОЛОН IPO ГАРГАСАН ЖИЛ БОЛЛОО



Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд нэг жилийн дотор хамгийн олон компани IPO гаргасан үйл явдал 2018 онд тохиолоо. Нийтдээ таван компани 30.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс амжилттай татан төвлөрүүллээ.

Үнэт цаас шинээр гаргасан компаниуд дотор банк бус санхүүгийн байгууллага, даатгалын хоёр компани багтсан бөгөөд эдгээр салбарт IPO гаргасан анхны тохиолдол боллоо.

8. “ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ 2018–2023” БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ БАТЛУУЛЛАА

“Зээлийн хүүг бууруулах стратеги 2018–2023” болон уг стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталлаа. Санхүүгийн зохицуулах хороо 2018-2023 онд зээлийн хүүг бууруулахад чиглэсэн зургаан зорилтын хүрээнд 30 орчим ажлыг тэргүүлэн болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Хорооны зохицуулалтад багтдаг банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн сарын жигнэсэн дундаж хүү сүүлийн 7 улирал дараалан буурч 3.3 хувьд хүрсэн, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 10.6 болж



буурсан, салбарын үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч байна. Цаашид Санхүүгийн зохицуулах хороо олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бий болгох, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэд, олон нийтэд хямд үнэтэй өргөн сонголт бүхий санхүүжилтийн арга хэрэгслийг санал болгох чиглэлээр олон ажил төлөвлөн хэрэгжүүлж байна.

9. ФИНТЕКТ СУУРИЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ НЭВТЭРЧ, ХАРИЛЦАГЧДЫН ТОО 1.5 САЯД ХҮРЛЭЭ

Санхүүгийн зах зээлд финтек буюу дэвшилтэт, цахим технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх санаачилга, бүтээлч үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороо дэмжин ажиллаж байна.

Үүний үр дүнд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлдэгчдийн тоо 2017 оныхоос 2.1 дахин нэмэгдэж 218 мянгад хүрснээр нийт харилцагчдын тоо 1.5 саяыг давлаа. 2018 оны гуравдугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын харилцагчдын 83.1 хувь, нийт зээлдэгчдийн 40.7 хувь нь технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэж байна.

10. ББСБ-УУДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙГ ЦАХИМААР АВЧ ЭХЭЛЛЭЭ

Санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, хуулийн этгээдийг бүртгэх, тайлан хүлээн авах, хяналт тавих болон өөр хоорондоо мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх нэгдсэн нэг цогц систем бий болгох ажил дуусах шатандаа орлоо. Эхний ээлжид банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хүсэлт, материалыг хүлээн авч байна.

Нэгдсэн мэдээллийн сан бий болгох цогц ажлыг энэ оны хоёрдугаар улиралд бүрэн дуусгах бөгөөд ингэснээр Хорооны зохицуулалтад буй санхүүгийн бусад салбар буюу үнэт

цаасны, даатгалын болон хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх ажил бүрнээ цахимжих юм.

11. ТӨЛБӨРИЙН ЭСРЭГ НИЙЛҮҮЛЭЛТ (DELIVERY VERSUS PAYMENT)-ИЙН ЗАРЧИМ, ДАРАА ТӨЛБӨРТ ТООЦОНЫ Т+2 ГОРИМЫГ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЭХ ТӨСӨЛ ЭХЭЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD)тай хамтран “Монгол Улсын хөрөнгийн зах зээлд төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) болон Т+2/3 зарчмыг нэвтрүүлэх” төслийг хэрэгжүүлж эхэллээ.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Монголын үнэт цаасны төлбөр тооцооны тогтолцоог шинэчилж, олон улсын стандартад нийцүүлэх, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн нэгдсэн системийг бий болгох ач холбогдолтой юм.

12. ДАВХАР БҮРТГЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН БИЙ БОЛЖ, АНХНЫ ДАВХАР БҮРТГЭЛТЭЙ КОМПАНИЙН ХУВЬЦАА ХӨРӨНГИЙН БИРЖИД АРИЛЖААЛАГДАЖ ЭХЭЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо давхар бүртгэл буюу Dual listingийн зохицуулалтын журмыг шинээр баталж мөрдүүлснээр 2018 онд Монголын хөрөнгийн зах зээлийн анхны давхар бүртгэл хийгдлээ.

Давхар бүртгэл хөгжсөнөөр Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах, мөн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах эрх нээгдэж байгаа бөгөөд үүний үр дүнд гаднын хөрөнгө оруулагчдын дотоодын зах зээлд хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэх, цаашлаад арилжааны идэвх сайжирч хөрвөх чадвар өсөхөд нөлөө үзүүлэх давуу талтай.

13. СЗХ-НЫ ДАРГА С.ДАВААСҮРЭН MEFIN-НИЙ 2019 ОНЫ ДАРГААР УЛИРАН СОНГОГДЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн 2016 оноос олон улсын Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (CXH, Alliance for Financial Inclusion, AFI)ийн Захирлуудын зөвлөлийн есөн гишүүний нэгээр ажиллаж байгаа. Тэгвэл тэрээр ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/ ийн “Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо” /Regulatory Framework Promotion of Propoor Insurance Markets in Asia, RFP/ хөтөлбөрийн хүрээнд бий болсон “Хүртээмжтэй даатгалын асуудлаарх харилцан мэдлэг, туршлага солилцох сүлжээ” буюу MEFIN сүлжээний 2018 оны даргаар ажилласан бөгөөд 2019 онд улиран сонгогдлоо.

Тус байгууллага нь зохицуулагч байгууллагууд болон зах зээлд оролцогч хувийн секторын байгууллагуудад тулгарч буй бэрхшээл, түүний шийдлийг олох, өөрийн оронд ашиглах боломж бүрдүүлдгээрээ онцлог юм. Сүлжээний 2019 оны даргаар Хорооны дарга С.Даваасүрэн улиран сонгогдсоноор тус хөтөлбөрийн дараагийн үе шатанд Монгол Улс манлайлах байр суурьтай оролцох боломжийг нээж байна.

14. “ХҮРТЭЭМЖТЭЙ ДААТГАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ”-Д ШАЛГАРАН ОРОЛЦЛОО

ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/, Дэлхийн манлайлын академи /GLA/ болон Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэгч Олон Улсын байгууллага /AII/ зэрэг байгууллагуудаас хамтран хэрэгжүүлсэн “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх төсөл”-д Монгол Улс шалгаран оролцлоо.

Тус төслийн зорилго нь хүртээмжтэй даатгалын салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг болохуйц шинэ санаа, шилдэг санаачилга, зохистой зохицуулалтын орчныг бий болгох зорилготой бөгөөд хэрэгжиж дуусах үед энэ чиглэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах, дэвшилтэт технологи, шийдэлд

суурилсан борлуулалтын сувгийг нэвтрүүлэх, төрийн зохицуулалтыг оновчтой болгох зэрэг өргөн хүрээний асуудлаар тодорхой шийдэлд хүрсэн байх явдал байв. Төслийн хугацаанд манай улсын баг Монгол Улсад даатгалын үйлчилгээг иргэдэд хэрхэн хүртээмжтэй хүргэх зураглал (roadmap), төлөвлөгөөний төслийг боловсруулж, “Үндэсний семинар” аар хэлэлцүүлээ.

15. AFI-Д ЗҮҮН ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮС НУТГИЙН САНААЧИЛГЫН ЗӨВЛӨЛИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛЛАА



Эгнээндээ 95 улс орны нөлөө бүхий 110 гаруй санхүүгийн зохицуулагч байгууллагыг нэгтгэн, хүртээмжийн бодлогыг олон улсын хэмжээнд зангидан хэрэгжүүлдэг дэлхийн хамгийн том нэгдэл болох “Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг”-т Хороо Монгол Улсыг төлөөлөн ажилладаг билээ. Энэхүү нийгэмлэг нь өнгөрөгч 2018 онд Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санаачилгын зөвлөлийг анх удаа байгуулсан ба зөвлөлийг нийгэмлэгийн бүтцэд бий болгох асуудлыг Санхүүгийн зохицуулах хороо ОХУ-ын Төв банк болон бусад улс орны санхүүгийн зохицуулагч нартай хамтран дэвшүүлж, идэвхийлэн ажилласаар есдүгээр сард Сочи хотноо болсон Дэлхийн бодлогын форумын үеэр тус бүс нутгийн зөвлөлийг албан ёсоор зарлалаа. Зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн санаачилгын зөвлөлд Монгол Улс, ОХУтай хамт Казахстан, Киргизстан, Тажикстан, Узбекистан улсууд багтаж байна.

Олон улсын санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)ийн үйл ажиллагааны үндсэн бүтэц нь Бүс нутгийн санаачилгын зөвлөлүүд бөгөөд 2018 оныг хүртэл тус нийгэмлэг Африкийн, Өмнөд америк болон Карибын тэнгисийн арлуудын, Ойрхи Дорнод болон Хойд Африкийн, Номхон далайн арлуудын гэсэн бүс нутгийн санаачилгын дөрвөн зөвлөлтэй ажиллаж ирсэн юм.

16. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ШАТ АХИУЛЛАА



Санхүүгийн зах зээлийн оролцогчдыг чадавхжуулах, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах Санхүүгийн зохицуулах хорооны зорилтын хүрээнд МБХ, МДХ, МДЗХ, МҮЦАЭХ, ММНБИ, ММУИ, Хөдөө аж ахуйн биржийн брокеруудын холбоо, Компанийн засаглалын хөгжлийн төв ТББ, МИСШН, ҮХХЗНХ болон МХХтой сургалт зохион байгуулах, судалгаа хийх, гадаад орны туршлага судлах, зах зээлд оролцогчдын мэргэжлийн ёс суртахууныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны дүрэмд заасны дагуу “Санхүүгийн зохицуулах хорооны даргын дэргэдэх Бодлогын зөвлөл”-ийг байгуулав.

17. ДАВХАР ДААТГАЛЫН АНХНЫ ХУВИЙН КОМПАНИД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛОО

Даатгалын компаниуд өөрийн хүлээж авсан эрсдэлээ шилжүүлэх зорилгоор өөр нэгэн даатгалын компаниас давхар даатгалын үйлчилгээг авдаг.

Санхүүгийн зохицуулах хорооноос Монгол Улсын анхны хувийн, үндэсний давхар даатгалын компанид тусгай зөвшөөрөл олголоо. Үндэсний давхар даатгалын компани байгуулагдсанаар эдийн засгаас гадагш чиглэж буй хөрөнгийн урсгалыг сааруулах, цаашлаад даатгалын зах зээлийг тэлэхэд томоохон ач холбогдолтой юм.

Манай улсын дийлэнх даатгалын компаниуд гаднын давхар даатгалын компанид эрсдэлээ даатгаж ирсэн ба сүүлийн жилүүдэд салбарын хэмжээнд жилд дунджаар 40 орчим тэрбум төгрөгийн хураамжийн зардлыг гаднын компани руу шилжүүлжээ.

18. “САНХҮҮГИЙН САЛБАРЫН КОМПЛАЕНС-2018” ФОРУМ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа



явуулж байгаа бүх оролцогчид, үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниуд, хууль хяналтын, олон улсын болон дипломат байгууллагууд, бусад төр, олон нийтийн байгууллагын оролцоотойгоор “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумыг зохион байгууллаа.

Тус форумгаар санхүүгийн салбарын дотоод хяналтын уламжлалт арга ажиллагааг комплаенсын орчин үеийн жишигт нийцүүлэн шинэчлэх, олон улсын стандарт, хэм хэмжээг нэвтрүүлж мөрдүүлэх, сургалт, арга зүйгээр хангах, сурах бичиг, гарын авлага болон холбогдох баримт материалыг боловсруулах, зохицуулалтын журам, зааврыг батлан мөрдүүлэх зэрэг тодорхой ажил, алхмуудыг тусгасан зөвлөмж гаргалаа. Тус арга хэмжээ нь банкнаас бусад санхүүгийн зах зээлд оролцогчдыг нийтээр хамруулсан анхны форум гэдгээрээ онцлог болж өнгөрлөө.

19. “FRC PLUS” ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Иргэд, олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор “FRC PLUS” итгэлийн уралдааныг улсын хэмжээнд уламжлал болгон явуулахаар санаачилж, анхны уралдааныг “Хөрөнгө оруулалт” буюу “FRC PLUS: INVESTMENT” сэдвийн дор зохион байгууллаа.

Уралдаанд 30 гаруй илтгэгч “Хөрөнгө оруулалтын эрсдэл ба өгөөж”, “Финтек-Хөгжил” гэсэн чиглэлүүдээс сонгон онолын мэдлэг, үнэт цаасны зах зээлд оролцсон хувийн туршлага болон илтгэх ур чадвараа сорин өрсөлдлөө. Тус үйл ажиллагаа нь цаашид санхүүгийн зах зээлийг таниулах, санхүүгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, шинээр нэвтэрч буй технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний онцлог, хүртэх өгөөж, хүлээх эрсдэл, хөгжлийн шинэ санаачилгыг дэлгэрүүлэх ач холбогдолтой юм.

ШИНЭ ЗАРЧИМ, БОДЛОГООР СТРАТЕГИА ТӨЛӨВЛӨН АЖИЛЛАЖ БАЙГАА МААНЬ БОДИТ ҮР ДҮНД ХҮРЭХ НЬ ЭРГЭЛЗЭЭГҮЙ

СЗХ, түүний удирдлагын үйл ажиллагаатай холбоотой шүүмжлэл сүүлийн үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн сүлжээгээр цөөнгүй гарч байна. Эдгээр асуудлуудын талаар тус СЗХ-ны Дотоод хяналтын хэлтсийн дарга Н.Нямдаваатай ярилцлаа.



СЗХ хэт хүнд сурталтай байна гэсэн шүүмжлэл их гарч байна. СЗХ үнэхээр аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийн хариуг хуулийн хугацаанаас хоцроож өгөөд байдаг юм уу?

Эхлээд СЗХ-нд ирсэн нийт албан бичиг, өргөдөл гомдлын талаар товчхон тоо баримт дурдъя. Энэ оны нэгдүгээр сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд СЗХ-нд нийт 12 625 албан бичиг ирсэн байна. Үүний 1 743 нь хариутай албан бичиг ба 99 хувь нь шийдвэрлэгдсэн, 359 өргөдөл, гомдол ирснээс 98 хувь нь шийдвэрлэгдсэн бол үлдсэн 1-2 хувь нь шийдвэрлэгдэх шатандаа явж байна.

СЗХ-нд ирүүлсэн хариутай албан бичиг буюу хүсэлтүүд нь салбарынхаа онцлог, ялгаатай байдлаас хамааран шийдвэрлэх хуулийн хугацаа нь өөр өөр байдаг. Доод тал нь ажлын 30 хоног, дээд тал нь ажлын 45 хоногийн дотор шийдвэрлэнэ гэж салбарынх нь хуулиудад заасан байгаа. Энгийн буюу зөрчлийн шинжгүй өргөдөл, гомдлын хувьд хуанлийн 30 хоног, харин зөрчлийн шинжтэй өргөдөл,

гомдлыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу нийт 58 хоногт багтаан шийдвэрлэдэг. Зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажиллагаа нь шүүх прокурорын байгууллагатай хамтран хийгддэг учраас шийдвэрлэх эцсийн хугацаа нь дан ганц СЗХ-ноос хамаарахгүй.

Олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгслээр гараад байгаа шүүмжлэлд зөрчлийн шинжтэй асуудлуудыг яриагүй байгаа юм. Тухайлбал IPO гаргах тухай хүсэлт бараг жил гаруйн хугацаанд шийдэгдсэн гэх мэт баримтууд яваад байгаа шүү дээ.

Өмнө хэлсэнчлэн асуудлыг шийдвэрлэх хугацаа салбарын онцлогоосоо хамааран өөр өөр. IPO гаргах хүсэлтийг шийдвэрлэх асуудлыг СЗХ тухайн компанийн засаглал, ил тод байдал, санхүүгийн чадавч, цаашлаад хөндлөнгийн дүгнэлт гаргасан андеррайтер, аудит, хөрөнгийн үнэлгээний компаниудаас холбогдох тайлбар дүгнэлт авах, нийтэд санал болгож буй хувь хэмжээ бодитой эсэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хангагдах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх гээд олон талаас нь судалж, хянадаг. Зарим тохиолдолд хүсэлт гаргагчийн ирүүлбэл зохих материал дутуу бий. Түүний дагуу СЗХ-ноос нэмэлт материал шаардахад өнөө компаниудаас дутуу материалаа ирүүлэхгүй бас уддаг. Үнэт цаас гаргаж байгаа компаниудад зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цаана хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах гэсэн маш том үүрэг хариуцлага байдаг учраас СЗХ маш хариуцлагатай хандах шаардлагатай. Тийм ч учраас долоо хэмжиж нэг огтол гэдэг шиг СЗХ-ноос сүүлийн хоёр жилийн хугацаанд тогтоол, шийдвэр гаргахтай холбоотойгоор санхүүгийн зах зээлийн 50 гаруй судалгааг хийсэн. Нэг тогтоол, шийдвэрийн цаана маш олон ажиллагаа, тооцоо судалгаа хийгддэг тул цаг хугацаа шаардагддаг гэдгийг нэмж хэлмээр байна.

Танай Дотоод хяналтын хэлтэс ямар чиг үүрэгтэй вэ? СЗХ-ны албан хаагчид үнэхээр хүнд суртал гаргасан, санаатай болон санамсаргүйгээр

хүсэлтийн хариуг удаашруулсан тохиолдлыг илрүүлбэл ямар арга хэмжээ авдаг вэ?

Манай хэлтэс нь СЗХ-г стратеги зорилго, зорилтоо амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомж, дээд газрын болон СЗХ-ны тогтоол шийдвэр, удирдлагын үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, жилийн ажлын төлөвлөгөө, бусад төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт, тэдгээрийн уялдаа холбоотой байдалд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй. СЗХ-ноос хүсэлт, албан бичгийн хариуг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байгаа, эсэх асуудлаар манай хэлтсээс удаа дараа хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар хүсэлт, албан бичиг ирүүлсэн байгууллагууд нь шаардагдах баримт бичгээ дутуу ирүүлсэн, нэмэлт материалаа нөхөж ирүүлэхдээ сар гаруйн дараа ирүүлсэн, зарим нь материалаа огт ирүүлэхгүй таг болчихсон гэх мэт СЗХ-ны үйл ажиллагаанаас хамаарахгүй тохиолдлууд илэрсэн. “Үнэт цаасны тухай хууль”-д СЗХ нь үнэт цаасыг бүртгүүлэх тухай хүсэлтийг ажлын 20 өдрийн дотор хянан, зохих шаардлага хангасан, бүрэн материалыг хүлээн авсан өдрөөс эхлэн хугацааг тооцохоор заасан байдаг. Тодруулбал, энэ ажлын 20 хоног бол зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс эхлэн тоолдог хугацаа гэдгийг онцолж хэлмээр байна. Гэтэл бүрдэл дутуу материал ирүүлээд, СЗХ-ноос тэр талаар мэдэгдсэнээс хойш олон хоног хугацаа өнгөрсний дараа дутуугаа нөхчихөөд анх хүсэлт өгсөн огноогоороо хариу авах хугацаагаа тооцох нь буруу. Мөн хуульд нэмэлтээр аудитын болон үнэлгээний тайлан, бусад нотлох баримт шаардагдах тохиолдолд ажлын 15 хүртэл өдрөөр сунгаж болно гэж заасан байгаа.

СЗХ-г стратеги, зорилтоо хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг гэж та ярилаа. СЗХ-ны стратеги, зорилтын талаар тодруулахгүй юу? Цаашдын бодлого зохицуулалт, хөгжлийн хэтийн төлөв юу байна вэ?

2018-2021 онд хэрэгжүүлэх ажил, бодлого зорилтоо тодорхойлсон стратеги, төлөвлөгөөг

СЗХ нийт хамт олноороо болон санхүүгийн салбарын мэргэжилтэн, судлаачдаар хэлэлцүүлэн, жил гаруйн хугацаанд шүүн нягталж баталсан. Өмнө нь СЗХ 2012–2016 онд баримтлан ажиллах стратегийг хэрэгжүүлсэн байдаг. Энэ стратегийг тухайн үед гадны донор байгууллагуудаас санхүүгийн дэмжлэг авч хийж байсан бол 2018–2021 оны стратегиа бид цэвэр өөрсдийн хүчээр, хамт олноороо хүн бүр оролцож хийсэн. Тэгэхээр энэ стратеги, төлөвлөгөө бидний өөрсдийн маань хүсэл, чадавх, нөөц боломжид тулгуурласан болохоор хэрэгжих, үр дүнд хүрэх нь илүү бодитой гэж ойлгож болно. Өмнөх стратегиар хийгдэж байсан болон хэрэгжүүлэхээр зорьсон зорилго, зорилтуудаа үргэлжлүүлж, үр дүнд хүргэхээс гадна цаашид санхүүгийн салбарын цар хүрээ, хүртээмжийг өргөжүүлэх, зохицуулалт, хяналтын үйл ажиллагаанд олон улсын стандарт, жишгийг нэвтрүүлэх, зохистой бүтэц бүхий санхүүгийн тогтолцоог бүрдүүлэх томоохон зорилтууд, эдгээрийг ажил хэрэг болгох бодит төлөвлөлтүүдээ нарийвчлан зурагласан. Тэр бүү хэл, ажилтан, албан хаагч бүрээр хүч, нөөцөө төлөвлөж, стратеги зорилтоо хэрэгжүүлэх арга замыг хүрэх үр дүн, түүнийгээ үнэлж хэмжих шалгуур үзүүлэлтүүдтэй нь нэг бүрчлэн төлөвлөсөн.

СЗХ–ны хүн хүч, нөөц боломж өр нь хэр хүрэлцээтэй байдаг вэ?

СЗХ өнөөдрийн байдлаар нийт 144 ажилтантай, тусгай зөвшөөрөл эзэмшигч 2304 орчим зохицуулалтын байгууллагуудад хяналт тавьж ажилладаг. Нэг хянан шалгагч дунджаар 76 аж ахуйн нэгжийг хариуцдаг. Хянан шалгагчлын ажлын ачаалал хэт их байх нь зайны болон газар дээрх хяналт шалгалтыг үр дүнтэй, ач холбогдолтойгоор зохион байгуулахад хүндрэлтэй нь мэдээж. Мөн нуулгүй хэлэхэд СЗХ–ны мэргэжилтэн сард дунджаар 500,000₮–ийн цалин авдаг. Гэтэл энэ нь статусаараа яг ижил байгууллагууд болох Монголбанк, Үндэсний Аудитын газар гэх мэт төрийн захиргааны байгууллагын цалинтай харьцуулахад 2–3 дахин бага байгаа юм. Салбартаа мэргэшсэн боловсон хүчнийг СЗХ–нд ажиллах санал тавьсан ч цалин бага учраас цалин өндөртэй байгууллагыг нь сонгож орж байна шүү дээ. Гэхдээ СЗХ–ны удирдлага болон албан хаагчид байгаа нөөц боломж дээрээ тулгуурлан идэвх санаачлагатай, өөрсдийгөө дайчлан ажиллаж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй.

Хүн хүчний хүрэлцээ хангалтгүй, хэт ачаалалтай ажилладаг гэлээ. Гэсэн атлаа багагүй тооны хүнийг халж, сольсон гэсэн тоо баримт бас хэвлэл мэдээллийн хэрэгслээр явсан байх юм.

Энэ нь ямар учиртай юм бэ?

СЗХ 2016 оны наймдугаар сараас өмнө нийт 29 нэгж, 36 удирдах албан тушаалтантай ажиллаж байсан. Үүнийг 13 нэгж, 14 удирдах албан тушаалтантай байхаар бүтцийн шинэчлэл хийсэн. Өөрөөр хэлбэл СЗХ–нд ажиллаж байсан гурван албан хаагч тутмын нэг нь удирдах албан тушаалтан байсныг гурав дахин бууруулж, гүйцэтгэх шатны албан хаагчдын тоог нэмсэн гэсэн үг юм. Үнэн хэрэг дээрээ удирдах албан тушаал дээр ажиллах сонирхолтой албан тушаал буурсан албан хаагчид сайн дураараа ажлаас гарсан. Мөн СЗХ–ны албан хаагчдын цалин бага байгаа нь ажилтнууд цалин өндөртэй байгууллагыг сонгож СЗХ–ноос гарах эрсдэлийг үүсгэж байна.

Санхүүгийн салбар бол мэргэжлийн салбар шүү дээ. СЗХ–нд мэргэжлийн бус хүмүүс их орж ирсэн гэсэн шүүмжлэл бас байна?

Манай нийт албан хаагчдын 80 хувь нь эдийн засаг, санхүүгийн мэргэжлийн хүмүүс байгаа. Бусад нь төрийн байгууллагад заавал байх шаардлагатай эрх зүйч, хуульч болон төрийн захиргааны удирдлагын мэргэжилтэй хүмүүс ажиллаж байна.

Албан хаагчдын цалин хөлс бага гэж та ярилаа. Гэтэл СЗХ–ны дарга С.Даваасүрэн 1.4 тэрбум төгрөгийн урамшуулал авсан гэх хэл ам бас нийгмийн сүлжээгээр яваад байгаа нь ямар учиртай юм бэ?

Тийм зүйл огт байхгүй ээ. Энэ бол ор үндэсгүй гүжирдлэг. СЗХ тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс жил бүр хуулийн дагуу зохицуулалт үйлчилгээний хөлс авч, улсын төсөвт төвлөрүүлдэг. 2017 он, 2018 оны эхний хагас жилд төсөвт төвлөрүүлсэн орлого төлөвлөгөөнөөс давсан. Төлөвлөгөөнөөс давсан орлогын тодорхой хувийг байгууллага зарцуулахыг зөвшөөрч юунд, ямар зориулалтаар ашиглахыг заасан хууль, Сангийн сайдын баталсан журам бий. Энэ хууль, журмын дагуу СЗХ давсан орлогоос 2017 оны эцэст, мөн 2018 оны эхний хагас жилд хоёр удаа буюу нийтдээ 1.4 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалт, эх үүсвэр дутагдаж буй ажлуудын санхүүжилт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах болон ажилтнууд, ахмад настнуудын нийгмийн асуудалд үзүүлэх тусламж дэмжлэг зэрэг зориулалтаар зарцуулсан. Энэ нь СЗХ–ны чадавхыг нэмэгдүүлэх, ажиллах орчныг бага ч болов сайжруулахад ихээхэн нэмэр болж байна. Мөн тодорхой хэсгээр нь ажлын үр дүнг харгалзан хамт олон, албан хаагчдыг урамшуулсан. Урамшуулалд хамрагдаагүй ажилтан, албан

хаагч нэг ч байхгүй, мөн хэн нэгэн удирдах албан тушаалтан давуу эрхээр илүү ихийг авсан зүйл ч огт байхгүй. Ажилтан, албан хаагчдыг үр дүнгийн гэрээний биелэлтийг үндэслэн тэгш, шударга урамшуулсан явдал цалин хөлс багатай тэдний урам зоригийг нэмэгдүүлж, амьжиргааг дэмжиж, тогтвор суурьшилтай ажиллах итгэлийг бэхжүүлж байна гэж СЗХ–ны хамт олон ихээхэн талархалтай байгааг хэлэх хэрэгтэй.

Хөндлөнгөөс ажиглаж байхад санхүүгийн зах зээл нэлээд идэвхжээд, СЗХ бас ч гэж идэвхтэй ажиллаж байх шиг харагдах юм. Гэтэл шүүмжлэл тасрахгүй байна. Тухайлбал, хэрэгжиж байсан олон улсын байгууллагын төслийг зогсоосон гээд л шуугиад байна?

Энэ асуудал нь Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага болох ЖАЙКА–гийн санхүүжилтээр СЗХ дээр хэрэгжиж байсан “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөлтэй холбоотой яриа л даа. СЗХ–ноос тус төслийг зогсоосон зүйл огтхон ч байхгүй. Төслийн нэгдүгээр үе шат 2014 оноос эхэлж 2017 оны зургадугаар сард дууссан. Энэ үед манай улс ОУВС–гийн хөтөлбөрт орсон. ОУВС хөтөлбөрийнхөө хүрээнд манай улстай хамтран ажилладаг бүхий л олон улсын байгууллагуудтай үйл ажиллагааныхаа уялдааг хангасан юм билээ. Ингээд нэг томоохон хамтрагч болох ЖАЙКА–гийн төсөл, хөтөлбөрүүдийг өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөртэйгөө уялдуулахаар болж, “Хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хоёрдугаар үе шатыг хойшлуулсан. Харин бид ЖАЙКА–тай хоёр талын яриа хэлэлцээг идэвхжүүлсний үр дүнд төслийн хоёрдугаар үе шатыг ирэх 2019 оны гуравдугаар сараас эхлүүлэхээр тохиролцоод, бэлтгэл ажлыг хангаад явж байна.

ЖАЙКА гэснээс СЗХ–ны гадаад харилцаа хэр тэлж байна вэ?

Санхүүгийн зах зээл, түүний зохицуулалтыг хоёр талын болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагүйгээр төсөөлөх аргагүй. Учир нь санхүүгийн харилцаа өөрөө хил заагүй харилцаа болсон. Тиймээс СЗХ гадаад харилцаандаа онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Тодорхой үр дүн ч гарч, СЗХ болон Монгол Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, зах зээлийн оролцогчдын бүс нутгийн болон олон улсын нөлөө харьцангуй дээшилж байна. Тухайлбал, СЗХ–ны дарга С.Даваасүрэн дэлхийн 95 орны 114 төв банк, зохицуулагч байгууллагуудыг эгнээндээ нэгтгэдэг Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн Захирлуудын зөвлөлийн есөн гишүүний нэгээр ажиллаж байна.

Мөн “Хүртээмжтэй даатгалын асуудлаар харилцан мэдлэг, туршлага солилцох сүлжээ” буюу MEFIN-ий энэ оны даргаар ажилласан төдийгүй ирэх оны даргаар улиран сонгогдоод байна. Энэ сүлжээгээр хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд Азийн санхүүгийн зохицуулагч байгууллагуудын оролцоог өсгөн нэмэгдүүлэх төсөл хэрэгждэг. Сүлжээний 2019 оны даргаар СЗХ-ны дарга С.Даваасүрэн улиран сонгогдсоноор уг төслийн дараагийн үе шатанд манай улс манлайлах байр суурьтай оролцох

өргөн боломжийг нээж буйг хэлэх хэрэгтэй. СЗХ өнөөдрийн байдлаар дөрвөн төсөл, нэг техникийн хамтын ажиллагаа, мөн нэг санамж бичгийн хүрээнд Дэлхийн банк (WB), Азийн хөгжлийн банк (ADB), Европын сэргээн босголт хөржлийн банк (EBRD), ЖАЙКА, Олон улсын хөрөнгө оруулалтын банк (IIB), БНСУ-ын санхүүгийн хяналт шалгалтын байгууллагатай төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байна. Өмнө ярьсан MEFIN сүлжээ болон Олон улсын хадгаламж зээлийн хоршоодын зохицуулагчдын холбоонд

гишүүнээр нэгдэж орлоо. Мөн сүүлийн хоёр жилийн хугацаанд ХБНГУ, БНСУ, Хонгконг, Япон, Их Британи Улсын зохицуулалтын байгууллага, Даатгалын хянан шалгагчдын Олон Улсын холбоо (IAIS), Үнэт цаасны хороодын Олон Улсын байгууллага (IOSCO)-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлж чадсан.

*Эх сурвалж: Өдрийн сонин.
2018.12.20 №252 (6095)*

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ОЛГОСОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛ, ЭРХИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ



Хороо үүнтэй холбоотой зохицуулалтын дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн баталсан бөгөөд Хорооны зохицуулалтын байгууллага, иргэний тоо ихсэж, түүнд олгох тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн гэрчилгээ, үнэмлэхний төрөл өсөж, үүнийг дагаад тэдгээрт олгох индекс, бүртгэлийн дугаарлалтыг нэмэх, мөн Хорооны зөвшөөрлийн цахим систем, мэдээллийн сан нэвтэрч байгаатай холбоотой бүртгэлийн үйл ажиллагааны дарааллыг тодорхой болгох, гэрчилгээ, үнэмлэхийг хэвлэмэл болгох, бүртгэлийг хялбаршуулах, цахим архив үүсгэх зайлшгүй шаардлага гарсан билээ.

2006 оны “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам” нь дээрх шаардлагад нийцэхээ больсон, уг журмын 60-аад хувь нь өөрчлөгдөж, нэмэлт орж байгаа тул журмыг шинэчлэн батлуулахаар Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн нэгдсэн бүртгэлийг үнэн зөв хөтлөх, гэрчилгээ, үнэмлэхийг хэвлэмэл болгох, зөвшөөрлийн цахим систем, мэдээллийн сан бий болгох, бүртгэлийн ажиллагааг хялбаршуулан, цахим архив үүсгэн ашиглах зорилгоор зохицуулалттай этгээдэд олгох гэрчилгээ, үнэмлэхний индекс, бүртгэлийн дугаарыг шинэчлэн тогтоож, зарим нэмэлт өөрчлөлт оруулан, гэрчилгээ, түүний хавсралт, үнэмлэхний загварыг нэгтгэн, уг журмыг шинэчлэн боловсруулсан.

“

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 23.2-г “Хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн бүртгэл хөтлөх журмыг Хороо батална” гэж заасны дагуу Хорооны 2006 оны 25 дугаар тогтоолоор “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-ыг баталсан. Уг журамд Хорооны 2007 оны 90, 2010 оны 161 дүгээр тогтоолоор тус тус 2 удаа өөрчлөлт оруулсан байна.

”

ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

2006 оноос хойш Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай, Компанийн тухай хуулиуд зэрэг шинэчлэн батлагдсантай холбоотой Хорооны зохицуулалтын тусгай зөвшөөрлийн 11, зөвшөөрлийн 8, бүртгэлийн 4, эрхийн 5 нийт 28 санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдсэн.

ШИНЭ ЖУРМЫН ТӨСЛИЙН БҮРТГЭЛИЙН ДАРААЛЛЫН ГОЛ ОНЦЛОГ

№	БҮРТГЭЛИЙН ДАРААЛАЛ
1	Хүсэлт гаргагч бүртгэлд хамаарах мэдээллийг цахим бүртгэлд шивж, цахимаар болон цаасаар Хороонд ирүүлнэ.
2	Бүртгэл хариуцсан албан хаагч ирүүлсэн материалын бүрэн гүйцэд эсэхийг хянаж, бичиг хэрэг рүү шилжүүлнэ.
3	Бичиг хэрэг хүлээн авч Холбогдох газар руу шилжүүлнэ.
4	Хүсэлтийг хянан шийдвэрлүүлэх албан хаагч нь Хороо өргөдлийг хүлээн авснаас хойшхи хугацааны өргөдөл гаргагч этгээдээс системээр болон цаасаар ирүүлсэн баримт бичиг, мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавьж ажиллах бөгөөд Хорооны хуралдаан буюу Хорооны даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.
5	Журмын 4.1–т заасан маягтад агуулах мэдээллийг үнэн зөв бөглөж, баталгаажуулан бүртгэл хариуцсан албан хаагчид шийдвэрийн хамт цаасаар болон цахимаар хүргүүлнэ.
6	Бүртгэл хариуцсан албан хаагч системд шийдвэрийг хавсаргаж, гэрчилгээ, үнэмлэхийг хэвлэж, индекс бүртгэлийн дугаар олгон, Хорооны даргад танилцуулан, албажуулж, хянан шийдвэрлүүлсэн албан хаагчид хүлээлгэн өгнө.
7	Нэгдсэн бүртгэл хариуцсан албан хаагч албажуулсан гэрчилгээ, үнэмлэхийг хүлээлгэн өгсний дараа 4.1–т заасан маягтын мэдээллийг нэгдсэн бүртгэлийн ангилал бүрээр цаасан болон цахим архив үүсгэнэ.

Хүсэлт гаргагч өөрөө анх Хороонд хандахдаа цахим системд мэдээллээ оруулж, цаасан болон цахим хэлбэрээр ирүүлэх бөгөөд бүртгэлтэй холбоотой ажилбарууд маш тодорхой болно. Ингэснээр зөвшөөрлийн системд цахим архив үүсгэж, тоон мэдээг тухай бүр шуурхай гаргах ашиглах боломж бүрдэнэ.

Нэгдсэн бүртгэлийг Хорооны хяналт, зохицуулалтад хамаарах зах зээл, салбар тус бүрээр ангилж, чиглэл бүрээр индекс, бүртгэлийн дугаар олгоно.

Хороо энэхүү журмаар тусгай зөвшөөрлийн

төрлийн ангилалд хамаарах хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газарт нэгжийн зөвшөөрлийн гэрчилгээ, бүртгэл, эрхийн ангилалд хамаарах хуулийн этгээдэд бүртгэл, эрхийн гэрчилгээ, эрх бүхий иргэнд үнэмлэх олгоно.

Дээрх индекс, бүртгэлийн дугаар нь зохицуулалттай этгээдийн ангилал, чиглэл нь нэмэгдэж хасагдах тохиолдолд бусад индекс бүртгэлийн дугааруудад нөлөөлөхгүй байхаар дугаарласан бөгөөд санхүүгийн бүтээгдэхүүн

нэмэгдсэн тохиолдолд дугаарлалтыг давхардуулахгүйгээр үргэлжлүүлэн олгоно.

Энэхүү журам батлагдснаар тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, түүний хавсралт, үнэмлэх хэвлэмэл болох, салбар бүрийн журмын хавсралтаар баталсан өөр өөр гэрчилгээ, түүний хавсралт, үнэмлэхний загварыг нэг загварт оруулах, мөн цахим систем ажиллаж эхлэхэд холбогдох тоон мэдээг хялбар гаргах, Хорооноос олгож байгаа тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх дараалал хялбар болох ач холбогдолтой юм.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ БОЛОХ СЭНДБОКС–ЫН ТАЛААРХ СУДАЛГАА

СЭНДБОКС ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ТУХАЙ

Санхүүгийн талбар уламжлалт банкны үйлчилгээнээс халин, технологид суурилан хөгжих хандлагатай болж байгаа буюу “санхүүгийн технологи /Финтек/-ийн хувьсгал явагдаж буй” гэх эрин үед бид амьдарч байна. Ийнхүү нөхцөл, байдал өөрчлөгдөж байгаатай зэрэгцэн тус салбарын зохицуулалтын орчин бодит байдалтай нийцэх, үүгээрээ тус салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдах болов.

Санхүүгийн хүртээмжийг сайжруулах асуудал нь санхүүгийн салбарын инновацийн чадавхиас ихээхэн хамаардаг бөгөөд тус салбарын “эрхзүйн зохицуулалтын хязгаарлалтаас үүдэн салбарын үйлдвэрлэлд шинэ санаачлагууд бий болох, улмаар тухайн шинэ санаачлагууд бодит амьдралд хэрэгжих боломж хумигдаж байна”. Өөрөөр хэлбэл, санхүүгийн зарим шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нь банкны өнөөгийн үйл ажиллагааны стандарттай нийцэхгүй байдал, цаашлаад хууль эрхзүйн тодорхойгүй байдал, бизнесийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагууд гэх мэт зохицуулалтын хязгаарлалтаас үүдэлтэй санхүүгийн байгууллагуудын хэт болгоомжлол нь тус салбарт шинэчлэл, дэвшил явагдахад саад болж байна. Үүнээс гадна байгууллага бүр хэдэн арван санхүүгийн технологийн компаниудтай туршилт хийж, маш их цаг, хөрөнгийг зарцуулан нарийн төвөгтэй байдал үүсдэг нь өнөөгийн бодит байдал бөгөөд эдгээр сорилтуудыг даван туулахад зохицуулагчид, шинийг санаачлагчдад туслах нэг арга зам нь “Сэндбокс /Sandbox/” юм.

Сэндбокс–ууд нь мэдээллийн технологи /IT/ зэрэг бусад орчинд нэлээд өргөн хүрээнд хэрэглэгддэг бөгөөд харин санхүүгийн салбарт нэвтрээд удаагүй байна. Санхүүгийн салбарт ашиглагдах болсон санаа нь ялангуяа “Финтек” гэж нэрлэгдэх шинэлэг техник, дэд бүтцийг ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосноор үүссэн сорилтуудыг шийдвэрлэхэд тулгуурлан гарч иржээ. Тодруулбал, санхүүгийн салбар дахь сэндбокс–ын ойлголт нь тус салбарын хурдацтай хөгжиж буй инновациатай нийцэх зохицуулалтыг хөгжүүлэх механизмтай холбоотой.

Түүнчлэн энэхүү үзэл баримтлал нь дижитал эдийн засагт одоогийн зохицуулалтаар

хамгаалагдаагүй буюу зохицуулагч байгууллагын хяналтгүй шинэ бизнесийн загваруудыг турших зохицуулалтын сэндбокс–ын хүрээнд хэрэглэгддэг. Эдгээр туршилтууд нь мөн л финтек салбартай холбогдох бөгөөд шинээр үүсч буй бизнесийн загваруудад зориулсан зохицуулалтын орчинг бий болгох өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах ач холбогдолтой. Эцсийн дүндээ сэндбокс–ын орчин нь хамгийн шинэлэг санаачилгыг дэвшүүлэгч компаниудын өсөлт, хөгжлийг финтек салбарын дүрэм, журмын хүрээнд, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг зөрчихгүй байхаар зохицуулалтыг бий болгох явдал юм.

СЭНДБОКС ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ

Санхүүгийн салбар дахь инновацийн үйл ажиллагаа нь өнөөгийн хүчин төгөлдөр зохицуулалтын хүрээнд тус зах зээлд шинээр нэвтрэн оролцогчдод төдийлөн хүртээмжтэй бус, харин зах зээлд байр сууриа олсон, үйл ажиллагаагаа төрөлжүүлэхийг хүсч буй томоохон компаниудад хамааралтай байна. Сэндбокс нь уг тогтсон байдлыг арилган, финтек үйлдвэрлэлийн бүх түвшинд туршилтын болон суралцах орон зайг үүсгэдэг бөгөөд бүтээгдэхүүн, техникийн шийдлүүдийн эх санааг санал болгож буй аливаа байгууллага, аж ахуй нэгжүүдэд нээлттэй юм. Үүний нэгэн адил, өнөөгийн зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, өмнө нь зөвшөөрөл авч байгаагүй буюу шинээр бүтээж байгаа бүтээгдэхүүнээ турших үүднээс сэндбокс–д оролцож болно.

Цаашилбал, сэндбокс нь финтекийн гарааны бизнесүүдэд эрхзүйн тогтолцооны саадыг үгүй хийж, ажиллах давуу талыг олгох ба үүний дүнд финтек компаниуд илүү хурдан хөгжих, санхүүгийн үйлчилгээг хүртээх уламжлалт аргатай өрсөлдөхүйц шийдлийг зах зээлд нэвтрүүлэх, хөрөнгийн зах зээл, улс орны эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөтэй болохыг судалгаанууд харуулж байна. Тухайлбал, PwC (2017) зөвлөх компанийн судалгаагаар бизнес эрхлэгчдийн 86 хувь нь санхүүгийн институциудын хоёрдмол утгатай, тодорхойгүй дүрэм журмаас үүдэлтэй хууль, эрх зүйн орчинд тулгарч буй асуудлууд нь бизнесийн өргөжилтөд сөргөөр нөлөөлж буйг, Дэлхийн банкны тооцон гаргадаг “засгийн

газруудын хувийн салбарын хөгжлийг дэмжсэн ухаалаг бодлого, зохицуулалтыг боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх чадвар”–ыг илтгэдэг засаглалын чанарын үзүүлэлтээр нэг хүнд ногдох ДНБ болон Засаглалын чанарын үзүүлэлтүүд хоорондоо эерэг хамааралтэй байгаа зэргийг дурдаж болно.

Мөн санхүүгийн салбарын нэр хүндтэй байгууллага болох “Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага” /IOSCO/ 2017 оны хоёрдугаар сард гаргасан “Санхүүгийн шинэ технологи /Финтек/-уудын тайлан”–даа “сэндбокс нь санхүүгийн технологийн компаниудад шинэлэг технологи, шийдлүүдийг туршиж болох уян хатан зохицуулалтын хүрээнд санхүүгийн үйлчилгээг санал болгох боломжийг олгодог зохицуулагч байгууллагууд итгэлтэй байдаг”–ийг онцолжээ. Энэ бүгдээс “ухаалаг зохицуулалт нь институциудад хөрөнгө оруулагчдын итгэлийг олоход туслах бөгөөд ингэснээр санхүүгийн системийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой” нь харагдаж байна.

БУСАД УЛС ОРНУУД ДАХЬ СЭНДБОКС–ЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


EY /Ernst & Young/ (2017)–оос гаргасан Финтек ашиглалтын индекс /FinTech Adoption Index/–д авч үзсэн хориод зах зээл дэх дижитал идэвхтэй хэрэглэгчдийн 33% нь финтек бүтээгдэхүүн, үйлчилгээг ашигладаг бөгөөд Их Британи улс хөгжингүй зах зээлд тэргүүлэх байр суурийг эзэлж, хятадын хэрэглэгчид санхүүгийн технологийн үр ашгийг хамгийн өндөр түвшинд буюу судалгаанд хамрагдагчдын 69% ашигладаг нь дэлхийн дунджаас хоёр дахин их үзүүлэлт ажээ. Ийнхүү эрэлт хэрэгцээ нь өссөөр байгаа санхүүгийн салбарын инновацийг дэмжихийн тулд түр хугацаанд хуулийн зохицуулалтын хязгаарлалтыг сулруулж, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг турших орон зайг бий болгохоор улс орнууд сэндбокс–ыг нэвтрүүлэн, ажил хэрэг болгож байна. Тодруулбал, Канад улс ICO /Initial Coin Offering/–г зохицуулалтын сэндбокс–ын орчинд хүлээн зөвшөөрч, токеныг бүртгүүлэх, танилцуулгын шаардлагыг хангахад туслах, мөн Сингапур улс сэндбокс–ыг эрчим хүч, хийн компаниудын хүрээнд зөвшөөрсөн бол Австрали улс илүү өргөн хэмжээнд буюу блокчейн, эрчим хүч, эрүүл мэнд, хөдөө

аж ахуй, нийгмийн чиглэлийн шинэ санаачлагуудаа дэмжих замаар сэндбоксыг тус тус нэвтрүүлжээ.

Анхны зохицуулалтын сэндбоксыг ажиллагаа Их Британи улсад 2015 онд эхэлсэн бөгөөд тус улс санхүүгийн салбарын хамгийн сайн, боловсронгуй зохицуулалттай орчинд тооцогдож, одоогоор финтекийн төв хэмээн нэрлэгдэх болсон. Түүнчлэн 2018 оны эхээр тус улсаас гадна Европ, Азид түлхүү төвлөрсөн 20 гаруй орон энэхүү ойлголт, үзэл баримтлалыг идэвхтэй судлан, бодит ажил хэрэг болгож, сэндбоксыг оролцогчдын санал хүсэлт, туршилтын үр дүн зэргийг үндэслэн зохицуулалтынхаа орчинг оновчтой болгохоор хүчин чармайлт гаргаж байна.

Эцэст нь дүгнэхэд сэндбокс нь шинийг санаачлагч, зохицуулагчдын хооронд утга учиртай, бүтээмжтэй хамтын ажиллагааг бий болгож, аж ахуйн нэгжийн хувьд эрсдэлийг бууруулж, хөрөнгө оруулагчдын тав тухтай байдлыг хангах гүүр болох юм.

Зураг. Дэлхий дээрх зохицуулалтын сэндбоксыг хэрэглээний өнөөгийн байдал:



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН СУДАЛГАА

/2018 оны 3 дугаар улирлын судалгааны үр дүн/

Энэхүү судалгаа нь иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоо болон санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг судлах зорилготой юм. Судалгааг санамсаргүй түүврийн аргаар хийж, Монгол Улсын хэмжээнд 1000 орчим иргэдийг хамруулсан. Санхүүгийн зах зээлийн оролцоог даатгал, зээл болон хөрөнгийн зах зээлийн хүрээнд авч үзэн, голчлон авдаг үйлчилгээ, санхүүгийн байгууллагын сонголтод нөлөөлдөг хүчин зүйлс болон оролцохгүй байгаа шалтгааныг тодорхойлсон. Өмнөх судалгаануудаар хөрөнгийн биржийн арилжаанд оролцдог эсэхийг тандахад иргэдийн 90 гаруй хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байгаагүй гэж хариулсан байдаг. Түүнчлэн, арилжаанд оролцож байгаагүй шалтгаанууд дотор арилжаанд хэрхэн оролцохоо мэдэхгүй, мэдээлэл байхгүй зэрэг шалтгаанууд хамгийн их жин эзэлдэг. Санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний онцлогоос хамааран иргэдийн сонголтод нөлөөлдөг хүчин зүйлс нь ялгаатай байх боломжтой тул судалгаанд үүнийг тодорхойлох зорилготой асуултууд оруулсан.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Санхүүгийн зах зээлийн хэрэглэгчийн итгэлийн судалгаа нь 2016 оны 3-р улирлаас эхлэн хийгдэж байна. Улирлын судалгааны асуулга нь санхүүгийн зах зээлийн талаарх ерөнхий мэдээлэлтэй холбоотой асуултаас гадна тухайн цаг үетэй холбоотой нэмэлт асуулыг агуулдаг.

Энэ удаагийн судалгаанд нийт 995 санамсаргүй сонгогдсон иргэд хамрагдсан бөгөөд судалгаа нь Улаанбаатар хот болон 21 аймгийг хамарсан. Нийт оролцогчдын 41.3 хувь нь эрэгтэй, 49.8 хувь нь Улаанбаатарт оршин суудаг бол 57.8 хувь нь 35-аас дээш насны иргэд, 42.2 хувь нь 35 ба түүнээс доош настай иргэд байна. Боловсролын хувьд иргэдийг доогуур болон дээгүүр боловсролтой гэж ангилсан. Доогуур гэдэгт дунд болон түүнээс доогуур боловсролтой иргэд, дээгүүр гэдэгт дээд болон техник мэргэжлийн ба түүнээс дээш боловсролтой иргэд орно. Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 55.5 хувь нь дээгүүр боловсролтой, 44.5 хувь нь доогуур боловсролтой байна.

Иргэдийн амьжиргааг сууцны төрөл болон

өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого гэсэн хувьсагчдаар тодорхойлж авч үзсэн. Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 50.9 хувь нь гэр болон хашаа байшинд амьдардаг бол 49.1 хувь нь орон сууцанд амьдардаг байна. Сууцны төрлөөс гадна өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан иргэдийг орлого бага болон орлого өндөр гэсэн 2 бүлэг болгон ангилсан. Эхний бүлэг буюу орлого бага гэдэгт өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого нь 200 мянга хүртэлх төгрөгтэй тэнцэх өрхийн иргэдийг, хоёрдох буюу орлого өндөр гэдэгт өрхийн гишүүнд ногдох сарын орлого нь 200 мянга ба түүнээс дээш төгрөгтэй тэнцэх өрхийн иргэдийг оруулсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн 35.8 хувь нь энэхүү ангиллын дагуу орлого бага, харин 64.2 хувь нь орлого өндөр гэсэн ангилалд багтаж байна.

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОО

Зээлийн зах зээл: Иргэдээс өнгөрсөн 6 сарын хугацаанд санхүүгийн байгууллагуудаас зээл авсан эсэхийг асуусан. Өмнөх улирлын


судалгаанд оролцсон иргэдийн 35.3 хувь нь зээл авч байсан бол 2018 оны 3-р улирлын байдлаар, иргэдийн 45.3 хувь нь зээл авчээ. Нийт иргэдийн 31.0 хувь нь арилжааны

банкнаас, 9.1 хувь нь ломбарднаас, 6.2 банк бус санхүүгийн байгууллага, 6.3 хувь нь хувь хүнээс зээл авчээ.

харьцуулахад 5.3 пунктээр өндөр байна.

Даатгалд хамрагдаагүй иргэдээс хамрагдаагүй шалтгааныг тодруулахад 29.4 хувь нь хэрэгцээ шаардлагагүй гэж хариулсан. Энэ нь 2016 оны 3 улиралтай харьцуулахад 10.8 пунктээр бага, 2018 оны 2 улиралтай харьцуулахад 3.7 пунктээр илүү байна. Харин даатгалын хураамж өндөр учраас хамрагдаагүй гэж 15 хувь хариулсан. Энэ хариулт 2016 оны 3 улирлаас хойш буурсаар байна. Даатгалд итгэдэггүй гэсэн хариулт 13.4 хувь байгаа нь 2016 оны 3 улиралтай харьцуулахад 1.1 пунктээр бага, 2018 оны 2 улиралтай харьцуулахад 1.4 пунктээр өндөр байна.

Зураг. Иргэдийн зээл авсан байдал



Зээл авсан иргэд нас, хүйс, сууцны төрөл, орлого, ам бүлийн байдал, байршил зэргээрээ харилцан адилгүй байна. Нийт иргэдийн 45.3 хувь нь зээл авсан ч энэ нь хот, хөдөөгөөр харилцан адилгүй байна. Тухайлбал, Улаанбаатарын иргэдийн 44.5 хувь нь зээл авсан байхад хөдөөгийн иргэдийн 47.5 хувь нь зээл авчээ. Харин хотын иргэдийн 31 хувь нь албан бус эх үүсвэрээс зээл авч байхад хөдөөгийн иргэдийн 27 хувь нь албан бус эх үүсвэрээс зээл авч байна. Банк бус санхүүгийн байгууллагуудаас хотод амьдардаг, орлого өндөртэй, иргэд илүү их зээл авдаг бол арилжааны банкаас орон сууцанд амьдардаг, хөдөөгийн, эмэгтэй, орлого багатай, болон 35-аас дээш насны хүмүүс илүү их зээл авсан байна. Харин ломбарднаас эмэгтэй хүмүүс илүү их зээлдэг байна.

хувьд барьцаа хөрөнгө, баталгаанд тавигдах шаардлага хоёр дахь гол шалтгаан болдог. Ломбардаар үйлчлүүлэхэд хамгийн чухал шалгуур нь үйлчилгээний түргэн шуурхай байдал байна.


Даатгалын зах зээл: 2018 оны 3 улирлын байдлаар нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 75.6 хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагдаагүй гэжээ. Энэ нь өмнөх улиралтай харьцуулахад ойролцоо түвшинд байна. Харин 21.8 хувь нь сайн дурын ямар нэг даатгалтай бөгөөд энэ нь өмнөх улиралтай харьцуулахад бага зэрэг өссөн, 2016 оны мөн үетэй харьцуулахад 12 пунктээр өндөр байна.

Даатгалын талаар мэдэхгүй, сайн дурын даатгалд хамрагдсан эсэхээ мэдэхгүй гэсэн хариулт буурсаар байна. Тухайлбал, даатгалын талаар мэдэхгүй гэсэн хариулт 2016 оны 3 улирлын судалгаатай харьцуулахад 14.2 пунктээр, 2018 оны 2 улиралтай харьцуулахад 1 пунктээр буурчээ. Сайн дурын даатгалд хамрагдалт нь иргэдийн нас, боловсрол болон байршил зэргээс хамааран ялгаатай байна. 35-аас дээш настай, өндөр орлоготой бөгөөд дээгүүр боловсролтой иргэдийн хувьд сайн дурын даатгалд хамрагдалт сайн байна.

Хөрөнгийн зах зээл: Иргэдийн 18.3 хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан гэж хариулсан бол 75.4 хувь нь үгүй, 6.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. 2018 оны 1 дүгээр улирлын судалгаагаар энэхүү асуултад 30.1 хувь нь мэдэхгүй гэж хариулж байсан бол 2018 оны 3 улиралд энэ хариулт 24 орчим пунктээр буурчээ. Сонирхож байсан иргэдээс 29.7 хувь нь өмнө нь хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байсан бол 69.2 хувь нь оролцож байгаагүй байна.

Боловсрол өндөр, орон сууцанд амьдардаг, өндөр орлоготой, эрэгтэй, хотод амьдардаг иргэдийн 20 гаруй хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан бол боловсрол бага, гэрт амьдардаг, орлого багатай эмэгтэй, хөдөө амьдардаг иргэдийн 10 гаруй хувь сонирхож байжээ.

Зураг. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцох сонирхол



Зураг. Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх, бүлгээр



Сайн дурын даатгалд хамрагдалтыг бүлгээр харахад боловсрол болон насны бүлэг гэсэн хоёр хувьсагчаар хамгийн их ялгаа байна. Дээгүүр боловсролтой иргэдийн 25.8 хувь нь

даатгалд хамрагдсан байгаа нь эсрэг бүлгээсээ 7.5 пунктээр илүү байна. Харин 35 наснаас дээш настай иргэдийн 24.2 хувь нь даатгалтай байгаа нь 35 ба түүнээс доош настай иргэдтэй

Хөрөнгийн биржийн арилжааг сонирхохгүй байгаа шалтгааныг асуухад 39.1 хувь нь арилжаанд хэрхэн оролцохоо мэдэхгүй, 66.2 хувь нь мэдээлэл байхгүй гэж хариулсан. 2018 оны 1 дүгээр улиралтай харьцуулахад мэдээлэл байхгүй гэсэн хариулт 3.6 пунктээр өндөр, арилжаанд хэрхэн оролцохоо мэдэхгүй


гэж хариулсан иргэд 7.2 пунктээр илүү байна. Түүнчлэн, 13.5 хувь нь арилжаанд оролцох хөрөнгө, мөнгө байхгүй шалтгаанаар сонирхдоггүй байна.

САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ИТГЭХ ИТГЭЛ БОЛОН МЭДЛЭГ

Судалгаанд хамрагдсан иргэдээс санхүүгийн зохицуулагч байгууллагууд болон зуучлагч байгууллагуудад итгэх итгэлийг 2016 оны 3, 2017 оны 1 болон 2, 2018 оны 1, 2 болон 3 дугаар улирлуудад тандан асуусан. Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, даатгалын компаниуд, арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон

хадгаламж зээлийн хоршоодод итгэх итгэлийг тандсан дүнг зураг 4-т харууллаа. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар эдгээр санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг 2016 оны мөн үетэй харьцуулахад бага зэрэг өөрчлөлтүүд гарсан байна. Тухайлбал, 2018 оны 3 дугаар улиралд Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, хадгаламж зээлийн хоршоод болон банк бус санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл бага зэрэг буурч, харин даатгалын компани болон арилжааны банкинд итгэх итгэл бага зэрэг өсжээ. Итгэдэг гэсэн хариулт буурсан байгууллагуудын хувьд итгэдэггүй гэсэн хариулт мөн буурч, харин мэдэхгүй гэсэн хариулт өссөн байна.

Зураг. Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл, нийт дүн



Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийн тандах судалгаанд оролцогчдыг нас, хүйс, сууцны төрөл, хот хөдөө болон орлогын түвшингээр нь ангилан харахад ялгаатай дүр зураг харагдаж байгаа нь сонирхол татаж байна. Тухайлбал, боловсролын түвшин доогуур, амьжиргааны түвшин бага (гэр хорооллын эсвэл орлого бага) бүлгийн иргэд аливаа санхүүгийн байгууллагын үйл итгэдэг үү гэсэн асуултад мэдэхгүй гэдэг хариултыг их өгсөн байна.

Арилжааны банкнаас бусад байгууллагуудад иргэдийн итгэх итгэл наснаас хамааран ялгаатай байна. Өөрөөр хэлбэл 35 ба түүнээс доош настай болон 35-аас дээш настай гэсэн хоёр насны бүлэг үүсгэн эдгээр байгууллагуудад итгэх итгэл нь энэ хоёр бүлгийн хувьд ялгаатай эсэхийг шалгахад арилжааны банкнаас бусдынх нь хувьд 5 хувийн түвшинд ялгаатай гэж гарлаа. Эдгээр байгууллагуудад итгэх итгэл залуу хүмүүсийн дунд сайн байна.

Иргэдийн Санхүүгийн зохицуулах хороо, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны компани, арилжааны банк, даатгалын компани зэрэг байгууллагуудад итгэх итгэл нь хүйсээс хамааран ялгаатай биш байна. Өмнөх улирлуудад хөрөнгийн биржид

итгэх итгэл хүйсээр ялгаатай байсан бол энэ удаад тийм дүр зураг ажиглагдсангүй.

Сууцны төрөл гэсэн бүлгийн хувьд арилжааны банкнаас бусад байгууллагын хувьд мөн л ач холбогдол бүхий ялгаатай байна. Санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд эсрэг бүлгийнхнээсээ илүү сайн байна. Эдгээр байгууллагуудад итгэдэг үү гэсэн асуултад мэдэхгүй гэсэн хариултыг гэр хороололд амьдардаг иргэд орон сууцанд амьдардаг иргэдтэй харьцуулахад нэлээд их өгчээ.

Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэдийн 38.3 хувь нь Санхүүгийн зохицуулах хороонд итгэдэг байхад гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд 21.9 хувь нь итгэдэг гэжээ. Санхүүгийн зохицуулах хороонд итгэх итгэл 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд 7.2 пунктээр нэмэгдсэн байхад, гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд буурсан байна. Гэр хороололд амьдардаг иргэдийн бараг тал нь хөрөнгийн биржид итгэдэг үү гэсэн асуултад мэдэхгүй гэж хариулсан нь орон сууцанд амьдардаг иргэдтэй харьцуулахад 16.9 пунктээр өндөр байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийг боловсролын бүлгээр нь харахад мөн л арилжааны банкнаас бусад байгууллагуудын хувьд итгэх итгэл ач холбогдол бүхий ялгаатай. Бүрэн дундаас дээш боловсролтой иргэдийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын компаниуд болон үнэт цаасны компанид итгэх итгэл нь эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад сайн байна. Бүрэн дундаас дээш боловсролтой иргэдийн 34.3 хувь нь Санхүүгийн зохицуулах хороонд итгэдэг байхад, бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой иргэдийн хувьд 23.7 хувь нь итгэдэг гэжээ. Харин боловсрол доогуур бүлгийн иргэд мэдэхгүй гэсэн хариултыг аль ч байгууллагын хувьд илүүтэй өгсөн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны хувьд 55.3 хувь нь мэдэхгүй гэсэн нь боловсрол дээгүүр хүмүүстэй харьцуулахад 15.5 пунктээр илүү байна.

Энэ удаагийн судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага гэсэн хоёр байгууллагаас бусад байгууллагын хувьд итгэх итгэл нь иргэдийн хаана амьдардаг хамааран ялгаатай байна. Тухайлбал, хотын иргэдийн хувьд хөрөнгийн биржид итгэх итгэл нь хөдөө амьдардаг иргэдтэй харьцуулахад 10.4 пунктээр илүү, харин итгэдэггүй гэсэн хариулт нь 1.7 пунктээр бага, мэдэхгүй гэсэн хариулт 8.5 пунктээр бага байна. Санхүүгийн зохицуулах хороонд итгэх итгэл хотын иргэдийн хувьд 8.9 пунктээр өндөр байхад мэдэхгүй гэсэн хариулт нь 10.9 пунктээр бага байна.

ДҮГНЭЛТ

Санхүүгийн зах зээлийн оролцоог даатгал, зээл болон хөрөнгийн зах зээлийн хүрээнд авч үзэн, голчлон авдаг үйлчилгээ, санхүүгийн байгууллагын сонголтод нөлөөлдөг хүчин зүйлс болон оролцохгүй байгаа шалтгааныг тодорхойлсон.

Нийт иргэдийн 45.3 хувь нь зээл авсан бөгөөд талаас илүү нь арилжааны банкнаас зээл авчээ. Иргэдийн авсан зээлэнд арилжааны банк дийлэнх хувийг эзэлсээр байна. Иргэдийн санхүүгийн байгууллагын сонголтод нөлөөлдөг хамгийн гол хүчин зүйл нь үйлчилгээний түргэн шуурхай байдал бол дараагийн хүчин зүйлс нь санхүүгийн байгууллагуудаар ялгаатай байна. Тухайлбал, арилжааны банкны хувьд зээлийн хүү, банк бус санхүүгийн байгууллагын хувьд барьцаа хөрөнгө, баталгаанд тавигдах шаардлага хоёрдох гол хүчин зүйл болж байна. Нийт 4 удаагийн судалгааны үр дүнгээс харахад

сайн дурын даатгалд хамрагдалт болон даатгалын талаарх мэдлэг нь хэрэглэгчийн нас, боловсрол, орлого болон сууцны нөхцөлөөс хамааран өөр бөгөөд тодорхой зүй тогтолтой байна. Үүнд, 35-аас дээш настай, өндөр боловсролтой, орлого өндөртэй бөгөөд орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд даатгалд хамрагдалт өндөр бөгөөд мэдлэг сайтай байна. Даатгалын талаар мэдэхгүй, сайн дурын даатгалд хамрагдсан эсэхээ мэдэхгүй гэсэн хариулт судалгааг хийж эхэлсэн 2016 оны 3 дугаар улирлаас хойш буурсаар байна. Тухайлбал, даатгалын талаар мэдэхгүй гэсэн хариулт 2016 оны 3 дугаар улирлын судалгаатай

харьцуулахад 14.2 пунктээр, 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад 1 пунктээр буурчээ.

Иргэдийн 20 орчим хувь нь хөрөнгийн зах зээлд оролцохыг сонирхож байсан ч ердөө 5.4 хувь нь арилжаанд оролцож байжээ. Хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол бүлгүүдээр харилцан адилгүй байна. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцохгүй байгаа гол шалтгаанууд нь мэдээлэл байхгүй, хэрхэн оролцохоо мэдэхгүй гэж хариулсан.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл 2016 оны мөн үетэй харьцуулахад буурсан байна. Тухайлбал, 2018 оны 3 дугаар улиралд

Санхүүгийн зохицуулах хороо (2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад), хөрөнгийн бирж, хадгаламж зээлийн хоршоо болон банк бус санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл бага зэрэг буурч, харин даатгалын компани болон арилжааны банкинд итгэх итгэл бага зэрэг өсжээ. Итгэдэг гэсэн хариулт буурсан байгууллагуудын хувьд итгэдэггүй гэсэн хариулт мөн буурч, харин мэдэхгүй гэсэн хариулт өссөн байна. Санхүүгийн зохицуулах хороонд итгэх итгэл 2018 оны 2 дугаар улиралтай харьцуулахад орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд 7.2 пунктээр нэмэгдсэн байхад, гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд 5.1 пунктээр буурсан байна.

“МОНКОРД” ХЗХ-НЫ УДИРДЛАГУУД ХУУРАМЧ ТАЙЛАН ИРҮҮЛЖ БАЙСНЫГ УРЬДЧИЛАН ТОГТООСОН

Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)-д дотроо томоохонд тооцогдох “Монкорд” ХЗХ-ны үйлжиллагаа доголдож, гишүүдийнхээ хадгаламжийг өгч чадахгүй байна гэх мэдээлэл олны анхаарлыг татах болсон. Энэ талаар Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны Хадгаламж зээлийн хоршооны газар (ХЗХГ)-ын дарга Ц.Алтантуулаас тодруулж, ярилцлаа.



–Сүүлийн үед хэвлэл, олон нийтийн сүлжээгээр “Монкорд” ХЗХ-ны талаар таагүй мэдээлэл дуулдах боллоо. Яг юу болоод байгаа талаарх мэдээллээс ярилцлагаа эхлэх үү?

–Тэгэлгүй яах вэ, гол асуудлаа шуудхан л ярьсан нь дээр. “Монкорд” ХЗХ-ны санхүү, төлбөрийн чадвар муудсан, өөрийн хөрөнгө зохих хэмжээнд хүрэхгүй болж эрсдэлд орсон байдалтай байгаа. СЗХ-ноос гишүүн шинээр элсүүлэх, зээл олгох, хадгаламж татан төвлөрүүлэхийг нь зогсоон, зарим асуудлыг хууль, хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн байгаа. СЗХ-ны дэд дарга Д.Баярсайханаар ахлуулсан “Монкорд” ХЗХ-нд үүссэн нөхцөл байдлыг судалж шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэг томилоод ажиллаж байна. Мөн тус хоршоонд газар дээрх

шалгалт хийх ажлын хэсэг байгуулж, өнгөрөгч оны 11,12 дугаар сард бүтэн ажиллалаа. Шалгалтын дүгнэлт харахан эцэслэж гараагүй байна. Урьдчилсан байдлаар санхүүгийн бүртгэл, тайлан хөтлөлт, мэдээллийн ил тод болон үнэн зөв байдлын хувьд нэлээд тооны зөрчил дутагдал илэрч байна. Ер нь тус ХЗХ-нд дутагдал, доголдол гарах болсныг бүр 2016, 2017 оноос СЗХ эрх, үүргийнхээ хүрээнд шалгаж, нягталж, анхааруулж, үүрэг даалгавар өгч, торгох зэргээр хариуцлага тооцох хүртэл арга хэмжээ авч байсан. Харамсалтай нь, үйл ажиллагаагаа сайжруулж чадахгүй явсаар ийм байдалд хүрээд байна.

–Санхүүгийн зохицуулах хороо тус ХЗХ-нд 2016, 2017 оноос л арга хэмжээ авч байсан гэлээ. Энэ талаар тодорхой мэдээлэл өгөөч?

–СЗХ зохицуулалтын байгууллагууддаа байнгын хяналт тавьж, ажилладаг. Санхүүгийн тайланг нь улирал тутам хянах замаар зайны хяналтыг хийж, шаардлагатай бол газар дээр нь очиж шалгадаг. “Монкорд” ХЗХ ирүүлбэл зохих улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээ, тайлант жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, дүгнэлт болон бүх гишүүдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд зарлан хуралдуулж, хурлаас гарсан шийдвэрийг тухай бүр хууль, журмаар тогтоосон хугацаанд ирүүлж байсан. Ирүүлсэн тайланг СЗХ хянаж, илэрсэн дутагдалд нь тухай бүр дүгнэлт өгч ажилласан. Тухайлбал, тус хоршоо 2015 оны дөрөв, 2016 оны нэг, хоёр, гуравдугаар улиралд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй талаар 2016 оны есдүгээр сард

анхааруулж, үйл ажиллагаагаа сайжруулах үүрэг, даалгавар өгч байсан. Ер нь "Монкорд" ХЗХ-ны үйл ажиллагаанд 2007, 2009, 2012, 2014, 2015, 2017 онд газар дээрх хяналт шалгалт хийж байсан. 2017 оны шалгалтаар илэрсэн зөрчлүүдэд нь дүгнэлт өгч, тухайн үеийн хоршооны дарга, гүйцэтгэх захирал нарт нийт есөн төрлийн үүрэг даалгавар өгч байсан. Үүрэг даалгаврыг биелүүлэх талаар "Монкорд" ХЗХ ажилласан ч СЗХ хангалтгүй гэж үзсэн. Хамгийн гол нь санхүү, төлбөрийн чадвараа сайжруулах талаар үр дүнтэй ажил хийж чадахгүй байсан.

–ХЗХ санхүү, төлбөрийн чадвараа сайжруулж чадахгүй тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо ямар арга хэмжээ авдаг юм бэ?

–СЗХ үүрэг даалгавраа биелүүлэхийг хүлээгээд зүгээр суугаад байхгүй л дээ. ХЗХ-ны сонгуульт гишүүд болон гүйцэтгэх удирдлагатай нийт таван удаагийн уулзалт зохион байгуулж, удаа дараа үүрэг даалгавар, мэдэгдэл, анхааруулга өгч байсан. Ингээд тус ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа өнгөрөгч 2018 оны зургаадугаар сарын 30-наар дуусгавар болсон тул тэд сунгуулах хүсэлтээ ирүүлсэн. Гэвч хоршооны хадгаламж эзэмшигч гишүүдээс гомдол ирсэн байсан, өмнөх хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй зэрэг дутагдал байсаар байсан тул тус ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сунгах эсэхийг газар дээрх шалгалтын дүгнэлтэд үндэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзээд долоодугаар сард очиж шалгасан. Шалгалтаар хоршооны санхүүгийн анхан шатны болон ерөнхий дэвтрийн үлдэгдэл, нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүйн улмаас шалгалтын ажлын хэсэг тохируулсан тайлан бэлтгэж, шалгах өдрийн байдлаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бодитоор тооцож, дүгнэлт өгөх боломжгүй байдал үүссэн.

–Миний сонссоноор "Монкорд" ХЗХ анхны хоршоодын нэг юм байна. Санхүүгийн үзүүлэлтүүд нь хамгийн сүүлчийн байдлаар ямар байв?

–"Монкорд" ХЗХ нь 1996 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа, манай анхны хоршоодын нэг. Өмнө нь 2005–2006 оны үеийн ХЗХ-дын хямралыг ч даван туулж чадсан хоршоодын нэг. Хороонд ирүүлж байсан тайлангийн мэдээллүүд ихээхэн эргэлзээтэй тул тодорхой тоо хэлэх боломжгүй байна. Учир нь, газар дээрх шалгалтаар бид хоршооны гүйцэтгэх удирдлагууд санхүүгийн тайлангаа үнэн бодитой гаргадаггүй байсныг урьдчилан тогтоогоод байгаа. Энэ бол маш ноцтой асуудал. Бид Цагдаагийн ерөнхий

газрын Мөрдөн байцаах албанд тус ХЗХ-ны эрх бүхий албан тушаалтнууд бичиг баримт хуурамчаар уйлдэж, нотариатаар баталгаажуулсан байх магадлалтай зээлийн гэрээнүүд, эрх бүхий албан тушаалтан буюу тухайн үед ажиллаж байсан гүйцэтгэх захирал нь санхүүгийн баримт, материалыг хуурамчаар уйлдэж, төрийн байгууллагаас зөрчлийг нуун дарагдуулж байсан эсэхийг шалгуулахаар хандаад байна.

–"Монкорд" ХЗХ-ны гүйцэтгэх удирдлагууд Санхүүгийн зохицуулах хороог төдийгүй гишүүдээ хүртэл хуурч байсан байх нь уу?

–ХЗХ бол зөвхөн гишүүдээ үйлчилдэг, ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн бус байгууллага шүү дээ. Бүтэц, зохион байгуулалтыг нь нарийвчлан хуульчилж, тусгай зөвшөөрлийг нь гурван жилээр олгохоор зохицуулсан. Бүх гишүүдийн хурлаараа хэлэлцэж сонгосон тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон гүйцэтгэх удирдлагатай. "Монкорд" ХЗХ ч хуулийн дагуу яг л энэ бүтэц зохион байгуулалтаар ажиллаж ирсэн. Өнгөрөгч оны долоодугаар сард хийсэн газар дээрх шалгалтаар тус хоршооны гүйцэтгэх удирдлага нь тэргүүлэгчдийн зөвлөл болон гишүүдээ үйл ажиллагаа хэвийн явж буй мэтээр харагдуулж ирснийг илрүүлж, үүссэн нөхцөл байдлын талаар гишүүдээрээ хэлэлцүүлэхийг СЗХ-ноос үүрэг болгосон. Үүний дагуу бүх гишүүдийн хурлаа хийж, энэ хуралд хоршооны гүйцэтгэх удирдлагууд 2012 оноос хойш санхүүгийн хоёр тайлан хөтөлж ирсэн гэдгээ хүлээсэн нь хурлын тэмдэглэлд тусгасан байна. Ер нь "Монкорд" ХЗХ-ны үйл ажиллагаа доголдоод байна. Удирдлагын буруу бодлогоос хүндрэлд орох аюул ойрхон гэдгийг зарим гишүүн нь бүр 2012, 2013 оны хурал дээрээ ярьж, анхааруулж байсан нь одоо ил гарч байна. Тухайн үед эдгээр мэдээллийг СЗХ-нд ирүүлдэг хурлын тэмдэглэл зэргээс хасчихдаг байсан байгаа юм.

–Гишүүд нь Санхүүгийн зохицуулах хороонд хэзээнээс хандаж эхэлсэн бэ?

–"Монкорд" ХЗХ гишүүдийнхээ хадгаламжийг анхны шаардлагаар буцаан олгоогүй гэх гомдол СЗХ-нд 2016 онд нэг, 2017 онд гурав ирсэн. 2018 онд энэ тоо 43 болсон. СЗХ өргөдөл, гомдлын дагуу сүүлийн гурван жилд "Монкорд" ХЗХ-нд нийт долоон удаагийн зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар алдагдсан шалтгааныг тогтоох явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрснийг би дээр хэлсэн. СЗХ хүчний байгууллага биш тул гэмт хэргийн шинжтэй асуудал илэрсэн тохиолдолд

холбогдох баримтыг хуулийн байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлдэг. "Монкорд" ХЗХ-ны зарим баримтыг бид харьяаллын дагуу Ерөнхий прокурорын газарт шилжүүлэн шалгуулж байна.

–Санхүүгийн байгууллагуудын тайлан тэнцлийг хөндлөнгийн аудитын байгууллагууд хянаж баталгаажуулдаг биз дээ?

–Тус ХЗХ-ны ирүүлж байсан тайланг бүгдийг л аудитаар хянуулж, "зөрчилгүй" гэж дүгнэсэн байдаг. Ийм тайланг гишүүдээ танилцуулж, Хороонд ч мөн ирүүлдэг байсан байгаа юм. Энэ талаар бид Сангийн яаманд мөн хандаж, "Монкорд" ХЗХ-ны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын байгууллага үнэн бодитой дүгнэлт өгсөн эсэхийг шалгуулж, дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.

–"Монкорд" ХЗХ-ны хуурамч тайланг аудитын ямар компани хянаж, баталгаажуулж байсныг нэр заан хэлж болох уу?

–2014, 2015 оны тайланг нь "Алтан жолоо аудит" компани, 2016, 2017 оныхыг нь "Мишээл од аудит" компани хянасан байдаг. Эдгээр компанийн асуудлыг бид Сангийн яаманд тавиад байна.

–СЗХ-ны дарга С.Даваасүрэн "Монкорд" ХЗХ-ны удирдлагуудыг хаацайлаад байна гэх хардлага олон нийтийн дунд байх шиг байна. Үүнд та ямар тайлбар өгөх вэ?

–СЗХ-ны дарга энэ талаар хувийн твиттертээ тайлбар өгснийг хүмүүс харсан байх. С.Даваасүрэн даргад "Монкорд" ХЗХ-г хаацайлах ямар ч шалтгаан, үндэслэл байхгүй. Тус ХЗХ-ны гишүүд, хадгаламж мөнгөө авч чадахгүй яваа хүмүүс янз бүрийн сэжиг, хардлага дэвшүүлж байгаа нь тэр байх. "Монкорд" ХЗХ-ны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан М.Дэлгэрмаг СЗХ-ны даргын төгссөн дунд сургуулийг дүүргэсэн, түүгээрээ холбоотой байж магад гэсэн яриаг тус ХЗХ-ны зарим гишүүн ярьсан байна билээ. СЗХ-ны дарга С.Даваасүрэн түүнээс цөөнгүй насаар эгч, нэг дунд сургуульд сурч байсан ч гэлээ олон оны зөрүүтэй төгссөн байж таарна. Иймэрхүү зүйлийг үндэслэл болгон хардаж, сэрдвэл одоо энэ асуудлыг хариуцаж байгаа СЗХ-ны дэд дарга тэр хүнтэй нэг их сургууль төгссөн гээд туйлшрах уу. Ингэж болохгүй ээ. СЗХ болон удирдлагууд "Монкорд" ХЗХ-ны асуудлыг хаацайлж, хамгаалсан зүйл огт байхгүй. Энэ асуудалд СЗХ анхнаас нь эрх хэмжээнийхээ хүрээнд зохих арга хэмжээг авч ирсэн. Цаашдаа ч авна.

–Үйл ажиллагаа нь доголдолтойг мэдсээр байж СЗХ тусгай зөвшөөрлийг нь сунгах гэж байсан гэсэн мэдээлэл бий?

–СЗХ–ны үйл ажиллагааг гутаах, харлуулах зорилготой матаас маягийн бичгийг зарим хүн УИХ–д явуулсан юм билээ. Тэр бичигт 2017 онд тусгай зөвшөөрлийг нь сунгах гэж оролдсон гэсэн утгатай өгүүлбэр байна билээ. Би өмнө хэллээ шүү дээ, “Монкорд” ХЗХ–ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 2018 оны зургаадугаар сарын 30–ны өдрөөр дуусгавар болсон гэж. Дуусгавар болоогүй тусгай зөвшөөрлийг сунгах тухай асуудлыг ярихгүй нь ойлгомжтой биз дээ. Тэгэхээр энэ зүгээр л ор үндэсгүй гүжирдлэг болох нь тодорхой байгаа биз.

–СЗХ–ны болон хууль, хяналтын байгууллагаар “Монкорд” ХЗХ–ны удирдлага гэмт хэрэг хийснийг нь хууль, хяналтын байгууллага тогтоовол гишүүдэд нийт хэчнээн хэмжээний бодит хохирол учруулах вэ?

–Хяналт шалгалтын ажил бүрэн дуусаагүй, шалгалтын дүгнэлт эцэслэн гараагүй учраас тодорхой мэдээлэл өгөх боломжгүй байна. Тэр байтугай бид гишүүдийн тоо, актив, пассивийн хэмжээ зэргийг нэг бүрчлэн дахин нягталж байна. ХЗХ–ны удирдлагын хууль бус үйлдлийн улмаас ийм нөхцөл үүссэн нь урьдчилсан байдлаар тодорхой болж байна. Санхүүгийн салбар итгэлцэл дээр тулгуурладаг. Өндөр өгөөжийн амлалт өндөр

эрсдэлийг дагуулдаг гэдгийг гишүүд мэдэж хоршооноос үйлчилгээ авдаг байсан байх л даа. “Монкорд” ХЗХ–ны захирлуудын үйлдлийг гэмт хэрэг гэж тогтоогоод хоршооны гишүүдэд хохирол учирлаа гэхэд буруутай этгээдээр хохирлыг барагдуулах арга хэмжээ авч таарна. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11–т ХЗХ нь бусдын өмнө хүлээх төрийн үүргийг хариуцахгүй бөгөөд төр нь хадгаламж, зээлийн хоршооны бусдын өмнө хүлээх үүргийг хариуцахгүй гэж зохицуулсан байдаг.

–Гишүүдийг хохироохгүй хоршоог сэргээн сайжруулж, үйл ажиллагааг нь тогтворжуулаад цаашаа явах боломж хэр байгаа вэ?

–Шалгалтын дүн эцэслэн гарахаар өмнө хэлсэн дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг саналаа боловсруулж, СЗХ–нд асуудлыг танилцуулж, шийдвэрлүүлнэ. Үүний дараа хоршооны гишүүдэд ч мэдээллийг өгнө. Ийм л зарчмаар явдаг. ХЗХ–ны салбар хамтын удирдлага, хяналттай, ихээхэн “ардчилсан” засаглал бүхий санхүүгийн тогтолцоо болохоор сайдах, муудах асуудал байнга л гарч байдаг. ХЗХ–ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээ, хүчингүй болголоо, сунгалаа, сэргээлээ гэсэн мэдээ, мэдээлэл манайхаас байнга л гарч байдаг шүү дээ. Тэр бүхний цаана өнөөдөр “Монкорд” ХЗХ дээрх шиг олон асуудлыг ярьж, маш их ажил

хийж байдаг юм.

–Эцэст нь ХЗХ–ны зах зээлийн өнөөгийн төлөв байдал, энэ зах зээлийг хөгжүүлэх талаар СЗХ–ноос ямар бодлого, зохицуулалт явуулж байгаа талаараа товч танилцуулахгүй юу?

–2018 оны гуравдугаар улирлын байдлаар улсын хэмжээнд нийт 288 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Нийт актив 192.3 тэрбум төгрөг. ХЗХ–дын 62 000 гишүүн манай улсын эдийн засгийн идэвхтэй хүн амын 3.2 хувийг эзэлж байна. Салбарын хэмжээний үзүүлэлтийг авч үзвэл 1 тэрбумаас дээш хөрөнгөтэй 21 ХЗХ нийт хөрөнгийн хэмжээ, гишүүдийн тоо, татсан хадгаламж, олгосон зээлийн хэмжээгээрээ салбарын 80 хувийг бүрдүүлдэг. Өнгөрөгч онд эдгээрээс хамгийн томд тооцогдох найман ХЗХ–ны үйл ажиллагаанд хэсэгчилсэн хяналт шалгалт хийхэд “Монкорд” ХЗХ дээр илэрсэн шиг нөхцөл байдал ажиглагдаагүй. Гэхдээ бид хяналт шалгалтаа цаашид улам гүнзгийрүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна. Ер нь СЗХ энэ салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхийн тулд чадавхжуулах, мэргэжлийн санхүүгийн байгууллага болгоход анхаарч, дунд хугацааны зорилтоо гаргаад, хэрэгжүүлж эхэлсэн.

Ярилцсан У.Орхон

Эх сурвалж: “Монголын мэдээ” сонин

ӨРГӨН ДУРАН

КОМПАЕНС ФОРУМ

Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын, банк бус санхүүгийн, хадгаламж, зээлийн хоршооны, үнэт цаасны болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын зах зээлийн мэргэжлийн холбоодтой хамтран “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумыг зохион байгууллаа.



Форумыг нээж УИХ–ын Эдийн засгийн Байнгын хорооны дарга Д.Дамба–Очир, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн нар үг хэллээ.

Байнгын хорооны дарга Д.Дамба–Очир, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, “Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”–үүдэд тусгагдсан Хорооны зохицуулалттай зах зээлүүдийн нийт санхүүгийн салбарт эзлэх хувийг 10–15 хувьд хүргэх зорилтод форумын үндсэн сэдэв болох комплаенсыг хэрэгжүүлэх нь чухал нөлөөтэйг дурдсан бол Хорооны дарга, доктор С.Даваасүрэн комплаенсын үйл ажиллагааг санхүүгийн салбаруудад нэвтрүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвх чармайлт, хамтын хүчин зүтгэл чухал болохыг онцлов. Тэрээр энэхүү форумыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, баримтлах бодлого, чиг хандлагаа тодорхойлдог байх зорилт тавин ажиллаж байгаагаа мэдээллээ.



“Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумын эхэнд Олон улсын валютын сангийн суурин төлөөлөгч Нэйл Сакер “Олон улсын валютын сан ба Монгол Улс” сэдвээр илтгэл тавилаа. Тэрээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болоод комплаенсын үйл ажиллагааг нэвтрүүлэх ажлууд нь зөвхөн санхүүгийн салбар төдийгүй цаашлаад



макро эдийн засгийн түвшинд ач холбогдол өндөртэй болохыг оролцогчдод тайлбарласан юм. Мөн Дэлхийн банкны ахлах эдийн засагч Ш.Алтанцэцэг “Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал болон гадаад дотоод эрсдэл”-ийн талаар илтгэж, богино болоод дунд хугацаандаа эдийн засгийн төлөв байдал үргэлжлэн эерэг байх шинжтэйг онцоллоо. Гэвч бүсийн болон бусад гадаад эдийн засгийн нөлөө хүчтэй хэвээр байх төлөвтэйг дуулгасан юм.

Мөн форумын нэгдсэн хуралдаанд Азийн хөгжлийн банкны эдийн засагч Л.Амар болон Санхүүгийн мэдээллийн албаны дэд дарга Т.Дуламсүрэн нар өөрсдийн илтгэлийг танилцууллаа. “Санхүүгийн салбар дахь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга зам” сэдэвт илтгэлдээ Л.Амар санхүүгийн салбаруудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа хэрхэн явагдаж болох талаар тайлбарлан, сэргийлэх арга техникүүдийг дэлгэрэнгүй танилцуулсан бол Т.Дуламсүрэн Ази номхон далайн бүсийн байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын явцыг мэдээлсэн юм. Түүнчлэн Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Л.Сонор Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог танилцуулж, Хорооны Захиргаа удирдлагын газрын дарга Б.Батзориг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр Хорооноос явуулж байгаа үйл ажиллагаа, бодлого, зорилтын талаар форумд оролцогчдод дэлгэрэнгүй тайлбарлав. Дараа нь Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх

хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Э.Сэргэлэнбаатар санхүүгийн гэмт хэргийн нөхцөл, хандлагын талаар илтгэж, тулгамдаж байгаа зарим асуудлаар танилцуулга хийв.

Нэгдсэн хуралдааны хоёрдугаар хэсгийн үндсэн илтгэлийг Хорооны Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн дарга Н.Хүдэрчулуун тавив. Тэрээр “Санхүүгийн салбарын комплаенсын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдэвт илтгэлдээ санхүүгийн салбаруудад Хорооноос хийсэн эрсдэлийн үнэлгээг танилцуулж, салбар бүрийн онцлог, тулгамдсан асуудлын талаар яриу. Илтгэлтэй холбогдуулан явуулсан панель-хэлэлцүүлэгт Монголын хадгаламж, зээлийн хоршоодын Үндэсний холбоо (МХЗХҮХ)-ны тэргүүлэгч Б.Насанжаргал, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо (МББСБХ)-ны ерөнхийлөгч А.Алтансүх, Монголын даатгалын холбоо (МДХ)-ны гүйцэтгэх захирал Ж.Батжаргал, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (МУЦАЭХ)-ны Удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр, Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо (ҮХХЗНХ)-ны үүсгэн байгуулагч, ТУЗ-ын гишүүн П.Одгэрэл нар оролцож, салбар бүрт тулгарч байгаа сорилт, бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаарх санал, байр сууриа илэрхийлэв. Хэлэлцүүлгээр төрийн зохицуулагч байгууллагаас мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж, сургалт, арга зүй, нэгдсэн удирдлагаар хангаж, хууль тогтоомж, журам дүрмийг мөрдүүлж ажиллах шаардлага байгааг онцолж байв.

Үдийн хойно “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форум салбар хуралдаануудаар үргэлжлэв. Салбар хуралдаануудаар Үнэт

цаасны, даатгалын, банк бус санхүүгийн, хадгаламж зээлийн хоршооны болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбаруудад комплаенсыг хэрхэн нэвтрүүлэх, зах зээл болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогт хэрхэн нийцүүлэх, холбогдох журам, дүрмийг батлах асуудлыг хэрхэн шийдвэрлэх зэрэг өргөн хүрээний сэдвээр ажил хэрэгч яриа өрнөлөө. Салбар хуралдаануудаас гаргасан санал, дүгнэлтийг нэгтгэн, форумын хаалтын нэгдсэн хуралдаанд эцэслэн хэлэлцэв.

“Санхүүгийн салбарын комплаенс 2018” форумд нийт 250 орчим зочид, төлөөлөгчид оролцсон бөгөөд нэгдсэн болон салбар хуралдаануудаар хэлэлцсэн комплаенсийн зарчмуудыг нэвтрүүлэхтэй холбоотой санал дүгнэлтүүдийг нэгтгэж, санхүүгийн салбарын дотоод хяналтын уламжлалт арга ажиллагааг комплаенсын орчин үеийн жишигт нийцүүлэн шинэчлэх, олон улсын стандарт, хэм хэмжээг нэвтрүүлж мөрдүүлэх, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороо мэргэжлийн холбоотой хамтран ажиллаж, сургалт, арга зүйгээр хангах, сурах бичиг, гарын авлага болон холбогдох баримт материалыг боловсруулах, зохицуулалтын журам, зааврыг батлан мөрдүүлэх зэрэг тодорхой ажил, алхмуудыг тусгасан зөвлөмж гаргахаар боллоо.

ХЭРЭГЛЭГЧ

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

2018 оны 6 дугаар сарын 19-нд иргэн “З”, мөн оны 9 дүгээр сарын 11-ний өдөр иргэн “Б”, мөн оны 12 дугаар сарын 10-нд иргэн “Э” нараас холбогдох нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагууд нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээллийг буруу оруулснаас дээрх иргэдийн зээлийн ангилал буурсан талаар тус тус өргөдөл, гомдлыг Хороонд ирүүлжээ.

Уг өргөдлийг хуулийн хугацаанд хянаж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга,

Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу Монголбанкны зээлийн мэдээллийн санд байх зээлдэгчийн мэдээллүүдийг буруу оруулснаас зээлийн ангилал буурсан байгааг тус тус тогтоон тухайн банк бус санхүүгийн байгууллагуудад холбогдох мэдээллийг залруулах тухай хугацаатай үүрэг даалгаврыг албан бичгээр өгч, залруулан дээрх 3 иргэдийн гомдлыг бүрэн шийдвэрлэв.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2018 оны 11 сарын 27-нд иргэн “Э”-ээс ирүүлсэн зээлийн гэрээний хүү, нэмэгдүүлсэн хүүтэй холбоотой өргөдлийг хуулийн хугацаанд хянаад зээлийн гэрээнд нэмэгдүүлсэн хүү тооцохоор заагаагүй тул тухайн хадгаламж, зээлийн хоршоонд уг иргэнийг гомдолгүй болгох тухай хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь хангуулсан байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2018 оны 10 дугаар сарын 22-нд иргэн “Д”-ээс нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдлийг тус Хороонд ирүүлсэн байна. Өргөдлийн дагуу тухайн банк бус санхүүгийн байгууллагаас тайлбар, тодруулга гаргуулан улмаар газар дээр нь очин анхан шатны баримтад үзлэг хийхэд өргөдөл гаргагчийн зээлтийн эргэн төлөлтийг хувийн дансаар хүлээн авсан байсан нь тогтоогдлоо. Гэвч энэхүү зөрчилд хариуцлага тооцох хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн байх тул уг банк бус санхүүгийн байгууллагад үйл ажиллагаагаа цаашид хууль журмын хүрээнд явуулахыг анхааруулан хэрэв энэ үйлдэл давтагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ авахыг сануулж, өргөдөл гаргагчид энэ талаар мэдэгдсэн байна.

2018 оны 11 дүгээр сарын 13-нд иргэн “М”-ээс нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагын хууль бус үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээлэл ирүүлснийг хянаж, холбогдох банк бус санхүүгийн байгууллагад үйл ажиллагаагаа хууль журмын хүрээнд явуулахыг сануулан хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулан энэ талаар өргөдөл гаргагчид хариуг хүргүүлсэн байна.

ИРГЭДИЙН ХУВЬЦААГ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ АРИЛЖААЛСАН ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 385 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Аргай бэст ҮЦК” ХХК-ийн

үйл ажиллагаанд хийсэн газар дээрх хяналт, шалгалтаар илэрсэн болон тус компанитай холбоотойгоор Хороонд ирүүлсэн нийт 10 өргөдлийг хянах явцад 1997-2004 онуудад харилцагчдын хувьцааг зөвшөөрөлгүйгээр арилжаалсан гэж үзэхээр нөхцөл байдал үүссэн.

Эдгээр үйлдлүүд нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 1994 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн Үнэт цаасны тухай хуулиар зөрчилд тооцогддоггүй байсан ба Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн 1.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Зөрчилд тооцох, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тухайн зөрчил үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулийн дагуу шийдвэрлэнэ.” гэж, 5 дахь хэсэгт “Шинээр зөрчилд тооцсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хүндрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.” гэж тус тус заасан.

Өөрөөр хэлбэл, дээрх иргэдийн хувьцааг зөвшөөрөлгүй арилжаалсан гэх үйлдлүүдэд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан зөрчлийн шинжгүй, мөн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг нөхцөл байдал тогтоогдсон тул Зөрчлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэх боломжгүй байв.

Иймд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн

25.1.9-д “шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх” гэж заасны дагуу тухайн үед ажиллаж байсан “Аргай бэст ҮЦК” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд иргэдийн хувьцааг хууль бусаар арилжаалах замаар тэдгээрийн хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан гэх үйлдлүүд нь гэмт хэргийн шинжтэй байх магадлалтай тул нэр бүхий 13 иргэнд холбогдох нийт 10 өргөдлийг Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албанд шалгуулахаар шилжүүлээд байна.

ИРГЭДТЭЙ УУЛЗАХ, ЗӨВЛӨГӨӨ, ЗААВАР, ЧИГЛЭЛ ӨГӨХ, ГАЗАР ДЭЭР НЬ ШИЙДВЭРЛЭХ

Тус Хороонд хандсан иргэдтэй уулзаж, ярилцан хэрэв ноцтой тохиолдол бол өргөдөл гомдол бичгээр гаргахыг зөвлөн, өргөдлийг хэрхэн гаргах болон өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн үйл явц, өргөдөл гаргагчийн эрх, үүргийн талаар дэлгэрэнгүй танилцуулж байна.

Нөгөө талаас, иргэдэд цаг хугацааны хувьд чиргэдэл үүсгэхгүйн үүднээс боломжтой тохиолдолд заавар, зөвлөгөө чиглэл өгөх, эсхүл газар дээр нь тухай бүр гомдлын мэдээллийг шийдвэрлэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Тухайлбал, холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигч, зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол бий тохиолдолд тухайн холбогдогчтой шууд холбоо тогтоон уг маргаантай асуудлыг шийдэх, холбогдогч этгээдээр нэн даруй шийдвэрлүүлэхээр чармайн ажиллаж байна.


ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Зохицуулалттай этгээдүүд: 54 ҮЦК болон тэдгээрийн салбар төлөөлөгч болох 21 ҮЦК, нийтдээ 75 ҮЦК 2018 оны 3 дугаар улирлын байдлаар үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт ҮЦК-ийн 32 нь хөдөө орон нутагт байршиж байгаа ба төвийн бүсэд 11, зүүн бүсэд бүсэд 3, хангайн бүсэд 12, баруун бүсэд 6 байна. Харин үлдсэн 43 ҮЦК нь Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувьцааны төвлөрөл: Аливаа хувьцаат компанийн нийтэд арилжаалагдаж буй хувьцааны дийлэнх хувь нь цөөн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн гарт байхыг хувьцааны төвлөрөл гэнэ. Компанийн нийт

гаргасан хувьцааны 5 хувиас дээш хувьцааг эзэмшдэг бол том хувьцаа эзэмшигч болдог бол 5 хувиас доошгүйг эзэмшдэг бол жижиг хувьцаа эзэмшигч болдог байна. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар ЗЗҮ-ээр эхний 10-т жагсаж буй компаниудын хүрээнд хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд нийт хувьцаа эзэмшигчдийн 0.1 хувь нь буюу том хувьцаа эзэмшигчид нийт гаргасан хувьцааны 87.8 хувийг эзэмшиж байгаа бол үлдсэн 99.9 хувь нь буюу жижиг хувьцаа эзэмшигчид нийт хувьцааны 12.2 хувийг эзэмшиж байна.




■ Жижиг хувьцаа эзэмшигч ■ Том хувьцаа эзэмшигч

ХАА-Н ГАРАЛТАЙ БАРАА, ТҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

2018 оны 3 дугаар улирлын байдлаар Хөдөө аж ахуйн биржийн гишүүн 13 брокерын компани Хорооноос тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж байна. Тэдгээрээс 4 брокер хөдөө орон нутагт байрладаг ба баруун бүсэд 2, зүүн бүсэд 1, төвийн бүсэд 1 брокер тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Харин үлдсэн 9 брокер Улаанбаатар хотод төвлөрөн ажилладаг байна.

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын компанийн салбар, зуучлагчдын тоо юм. Даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч компаниудын нийт 573



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


Улсын хэмжээнд нийт 540 банк бус санхүүгийн байгууллага 746 салбараар дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаагаас 85.9 хувь буюу 464 (610 салбар) нь Улаанбаатар хотод, үлдсэн 14.1 хувь нь болох 76(136 салбар) нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Монгол улсын 21 аймагт бүгдэд нь ББСБ-ууд үйл ажиллагаа явуулж байна. Хөдөө орон нутагт ББСБ-уудын нийт 136 салбар үйл ажиллагаа явуулж байгаагаас 50 нь төвийн бүсэд, 48 нь хангайн бүсэд, 23 нь зүүн бүсэд, үлдсэн 15 нь баруун бүсэд тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

Зээлийн үйлчилгээний тархалт: ББСБ-уудын зээлийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 2.1 дахин нэмэгдэж 217.6 мянгад хүрлээ. Эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу 18-64 насны хүн амын тоог зээлдэгчдийн тоонд харьцуулсан дүн 9 байна. Өөрөөр хэлбэл улсын хэмжээнд 18-64 насны 9 хүн тутмын нэг нь ББСБ-ын зээлийн үйлчилгээг хүртэж байна.

салбар, төлөөлөгчийн газар 21 аймаг болон Улаанбаатар хотод байршиж байна. Эдгээр салбарыг бүсээр ангилан харвал хангайн бүсэд хамгийн их буюу 92, төвийн бүсэд 65, баруун бүсэд 64, говийн бүсэд 62, зүүн бүсэд хамгийн бага буюу 50 салбар, төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна.

2016 оны жилийн эцэст нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 36700 төгрөг байсан бол 2017 оны жилийн эцэст 408.6 төгрөгөөр буюу 21.4 хувиар өсөж 44'565 төгрөгт хүрэв. Даатгалын нягтралыг ангиллаар авч үзвэл, нэг хүнд ногдох ердийн даатгалын хураамж 23.4 хувиар өсөж 44'157 төгрөг болсон бол урт хугацааны даатгалын хураамж 54.9 хувиар буурч 408.6 төгрөгт хүрсэн байна.

Харин орон нутагт уг харьцаа 154, Улаанбаатар хотын хэмжээнд 4 байна. Монгол улсын хэмжээнд ББСБ-аас зээл авсан нэг зээлдэгч дунджаар 3.7 сая байгаа нь хөдөө орон нутаг болон Улаанбаатар хотын хэмжээнд ижил байна.





ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 288 хадгаламж, зээлийн хоршоодын 186 ХЗХ нь нийслэл Улаанбаатар хотод, 102 ХЗХ нь хөдөө, орон нутагт бүртгэлтэй байна. Нийт хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын 38 нь баруун бүсэд, 10 нь зүүн бүсэд, 30 нь хангайн бүсэд, 24 нь

төвийн бүсэд байршиж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 186 ХЗХ-дын 91.9 хувь нь төвийн зургаан дүүрэгт, 8.1 хувь нь алслагдмал гурван дүүрэгт байна.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

2018 оны 3 дугаар улиралд шинээр гаргасан батлан даалтын 59.2 хувь нь буюу 29 нь Улаанбаатар хотод олгосон батлан даалт байсан бол 11 нь Хангайн бүсэд, 8 нь төвийн бүсэд, 1 нь зүүн бүс буюу Дорнод аймагт гаргасан батлан даалт байсан. Тайлант улиралд баруун бүсийн аймгуудад батлан даалт олгоогүй байна.



ХУАНЛИ 2018 ОНД БОЛСОН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ**2018.01.02**

“Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян” эхлэв.

2018.03.07

“Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн Үндэсний багуудын анхдугаар уулзалт боллоо.

2018.03.16 – 2018.04.27

Хөрөнгийн зах зээлд ажиллаж, хөрөнгө оруулж буй хүмүүсийн туршлага, мэдлэгийг олон нийтэд хүргэх, судлаачдын судалгаа, шинжилгээ хийх хүсэл сонирхлыг дэмжих, идэвхжүүлэх, энэ зах зээлд оролцох боломжууд, хүртэх өгөөж, эрсдэлийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “FRC PLUS: INVESTMENT” илтгэлийн уралдаан явагдаж “Нэг Монгол” ТББ-ын судлаач А.Нинжин “Санхүүгийн технологийн хөгжил, олон улсын туршлага” илтгэлээрээ тэргүүн байр эзэллээ.

2018.03.19

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн хүртээмжтэй даатгалын асуудлаарх Азийн орнуудын мэдлэг, туршлага солилцох сүлжээ (MEFIN, The Mutual Exchange Forum on Inclusive Insurance)-ний 2018 оны даргаар сонгогдлоо.

2018.04.17

Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх асуудлаар “Үндэсний семинар” болов.

2018.05.23

Давхар бүртгэлийн зохицуулалтын орчин бий болж, анхны давхар бүртгэлтэй компанийн хувьцаа хөрөнгийн биржид арилжаалагдаж эхэллээ.

2018.06.02

“Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян” өндөрлөн зохион байгуулсан Монголбанк энэ үеэр хэрэглэгчид, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх талаар явуулсан Хорооны үйл ажиллагааг үнэлэн талархлын цом гардууллаа.

2018.06.21

ББСБ-уудын тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар авч эхэллээ. Санхүүгийн зохицуулах хороо төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох, үйлчилгээ авахтай холбоотой зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх, ил тод байдлыг бий болгох зорилгоор зөвшөөрлийн цахим системийг нэвтрүүлж эхэллээ.

2018.06.28

Санхүүгийн тогтвортой байдлын Зөвлөл (СТБЗ)-өөс 2018–2023 онд хэрэгжүүлэх “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг баталлаа.

2018.06.29

Анхны хувийн, үндэсний давхар даатгалын компани болох “Анд ДД” ХХК-д тусгай зөвшөөрөл олголоо.

2018.09.14

Бодлогын зөвлөлийн анхдугаар хуралдаан боллоо. Хурлаар гишүүд салбар тус бүртээ тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар хэлэлцэж, зөвлөл цаашид юунд төвлөрч, хэрхэн ажиллах талаар санал солилцов.

2018.10 сар

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө болон харилцагч, зээлдэгчдийн тоо нэмэгдсээр харилцагчдын тоо 1.5 сая боллоо.

2018.11.15

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт, шалгалт хийх журам батлагдлаа.

2018.12.10

Үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллагууд, хадгаламж, зээлийн хоршоод болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбаруудыг оролцуулсан “Санхүүгийн салбарын комплаенс 2018” форум боллоо.

2018.12.26

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасны дагуу “Үнэт цаас барьцаалах тухай” журмыг батлав.



Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.



+976-51-264444



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



Санхүүгийн зохицуулах хороо